



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хууль журмын зөрүүтэй ойлголт, ажилтнуудын ажлын хариуцлагагүйгээс төрийн залгамж чанар алдагдаж зөрчил давтагдан гарч даатгуулагчид хохирсоор байгаа нь сангуудын тогтолцоо үр нөлөөгүй байгааг харуулж байна.

**Аудитын сэдэв: НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН**

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. Нийгмийн даатгалын хөрөнгийн зарцуулалтад тавих өдөр тутмын хяналтыг хангалттай түвшинд хэрэгжүүлээгүйгээс сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн хүрээнд зарцуулаагүй байна.	7
1.1. Нийгмийн даатгалын байгууллага нь өмнөх онуудад улсын хэмжээнд аян зарлаж иргэдийн ажилласан жилийг нийгмийн даатгалын улсын байцаагч баталгаажуулсан байгааг одоо үгүйсгэж тооцохгүй байгаа нь төрийн албаны залгамж чанар алдагдагдаж иргэд ажилласан жилээ дахин нотлох хүндрэл үүсч байна.	7
1.2. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олгохдоо НДҮЗ-ийн баталсан журмыг зөрчиж, өвчтний хэвтэн эмчлүүлсэн хугацаанд хийгдсэн шинжилгээ, оношлогооны төлбөр, зарим өвчтний эмчилгээний зардлыг давхардуулан илүү олгосон байна.	14
1.3. Ажилгүйдлийн тэтгэмж тогтоох арга зүйг ажилгүйдлийн тэтгэмж олгох журамд тодорхой зохицуулж өгөөгүйгээс иргэдэд сангаас олгох тэтгэмжийг харилцан адилгүй олгосон байна.	19
1.4. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд 2012-2018 онд арилжааны банкнуудад байршуулсан харилцах дансны хүүгийн орлогыг 265.5 сая төгрөгөөр бүртгэсэн байна.	26
1.5. Нийгмийн даатгалын хэлтэс нь он дамжсан НДШ-ийн авлагын үлдэгдэл ихтэй байхад авлагыг барагдуулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллаагүй байна.	26
БҮЛЭГ 2. Төсвийн захирагч нь хууль зөрчсөн шийдвэр гаргасны улмаас ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт төсвөөс 5.8 сая төгрөг олгож үргүй зардал гаргасан байна.	29
2.1. Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлээгүйгээс төсөвт учирсан 5.8 сая төгрөгийн хохирлыг барагдуулаагүй байна.	29
2.2. Аймгийн НДХ 2012-2018 онуудад шаардлагатай байгаа хөрөнгийн жагсаалт гарган эрэмбэлэн нэн шаардлагатай байгаа хөрөнгийг тухайн ондоо төлөвлөн ажилласан байна.	30
2.3. Аймгийн НДХ нь сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 2016 онд үндсэн хөрөнгө худалдан авах тендерийг зохион байгуулсан бөгөөд тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны АЗ сертификатгүй гишүүн томилж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар 46.1.1 дэх заалтыг зөрчсөн байна.	30
2.4. Байгууллагын хэрэгцээнд 2014 онд худалдан авсан тавилга эд хогшлыг гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй байсан зөрчилд Төрийн аудитын газраас төлбөрийн акт тогтоосон байна.	31
2.5. Урсгал болон хөрөнгийн зардалд тавих хөндлөнгийн болон дотоод хяналт үр дүнтэй хэрэгжүүлэн илэрсэн зөрчил дутагдалыг тухай бүрт нь арилган ажилласан байна.	32
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	34
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	38
ДҮГНЭЛТ	39
ЗӨВЛӨМЖ	40
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:	41
ХАВСРАЛТУУД:	41

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НД	Нийгмийн даатгал
НДД	Нийгмийн даатгалын дэвтэр
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮОМШӨД	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМ	Эрүүл мэнд
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМҮЗ	Эрүүл мэндийн үндэсний зөвлөл

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /төсвийн гүйцэтгэлийн тайлангаар/	7
Хүснэгт 2	Тэтгэврийн хэмжээг өөрчилсөн шийдвэрийн судалгаа	7
Хүснэгт 3	Тэтгэврийн даатгалын сангийн төлөвлөгөө гүйцэтгэл	8
Хүснэгт 4	Тэтгэвэр авагчдын хөдөлгөөний судалгаа	8
Хүснэгт 4'	Өндөр насны тэтгэврийг зөрүүтэй тогтоосон жагсаалт	9
Хүснэгт 5	Тэтгэмжийн даатгалын сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Хүснэгт 6	2014-2018 онд хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчлийн судалгаа	14
Хүснэгт 7	Төлбөр зөрчлийн барагдуулалт	14
Хүснэгт 8	ЭМ-ийн тусламж үйлчилгээний төлөвлөгөө гүйцэтгэл	15
Хүснэгт 9	Улсын эмнэлэгт үзүүлсэн ЭМ-ийн тусламж үйлчилгээний төлөвлөгөө гүйцэтгэл	15
Хүснэгт 10	Рашаанд сувилалд үзүүлсэн ЭМ-ийн тусламж үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэл	15
Хүснэгт 11	Хувийн хэвшлийн эмнэлэгт олгосон ЭМ-ийн тусламж үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэл	16
Хүснэгт 12	Хэвтэн эмчлүүлэгсдийн судалгаа	17
Хүснэгт 13	2017, 2018 онд санхүүжилт олгосон байдлыг харьцуулсан судалгаа	18
Хүснэгт 14	ЭМД-ын сангаас олгосон эмийн хөнгөлөлтийн зардал.	18
Хүснэгт 15	ҮОМШӨД-ын сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл	20
Хүснэгт 16	ҮОМШӨД-ын сангаас тэтгэвэр авагчийн тоо	20
Хүснэгт 17	ҮОМШӨД-ын сангаас тэтгэврийн даатгалын санд төлөх шимтгэлийн зардлыг тооцсон түүвэр	21
Хүснэгт 18	Ажилгүйдлийн даатгалын сангийн зарцуулалт	22
Хүснэгт 19	Ажилгүйдлийн даатгалын санд тогтоосон төлбөр зөрчлийн судалгаа	26
Хүснэгт 20	Сангуудын харилцах дансны хүүгийн орлогын судалгаа	27
Хүснэгт 21	НДС-ийн авлагын судалгаа	28
Хүснэгт 22	НДШ-ийн авлагын үлдэгдлийн судалгаа	28
Хүснэгт 23	Ажилчдад олгосон нийгмийн хамгааллын зардлын судалгаа	30
Хүснэгт 24	Хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл	32
Хүснэгт 25	Хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл	33

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	2012-2018 онд олгосон тэтгэвэр	8
Дүрслэл 2	2012-2018 шинээр тогтоосон тэтгэвэр	8
Дүрслэл 3	2012-2018 онд олгосон тэтгэмж	12
Дүрслэл 4	Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	12
Дүрслэл 5	ҮОМШӨД-ийн сангийн зарцуулалт	20
Дүрслэл 6	Нийт авлагад эзлэх хувийн жин	29
Дүрслэл 7	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл	31
Дүрслэл 8	Санал асуулгын нэгтгэл /Нийгмийн даатгалын үйлчилгээг хэрхэн үнэлэх вэ?/	34
Дүрслэл 9	Санал асуулгын нэгтгэл /Та нийгмийн даатгалд хамрагдах нь хэр зохистой гэж үздэг вэ?/	34
Дүрслэл 10	Санал асуулгын нэгтгэл /Та нийгмийн даатгалын талаар хэр мэдлэг, мэдээлэлтэй вэ?/	34
Дүрслэл 11	Санал асуулгын нэгтгэл /Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ хүртээмжтэй байна уу?/	35

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2019 оны А/45 дугаар тушаалын дагуу "Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн"-д Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: - Сангуудын тогтолцоо, хөрөнгийн зарцуулалт үр нөлөөтэй байгаа эсэх; - Нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлсэн хөрөнгийн болон нийгмийн хамгааллын зардлын зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын тасаг, Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдол шаардлагын зөвлөлийн 2012-2018 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	Төв банкны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасантай нийцэхгүй гэсэн тайлбар өгч, Баянхонгор аймаг дахь Монгол банкнаас холбогдох мэдээллийг авч чадаагүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон ажилтнуудын нийгмийн асуудал шийдвэрлэсэн байдал, тэтгэмж тусламж олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, статистик судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Б.Цэрэнчимэд, Ж.Өсөхбаяр, П.Амаржаргал нар гүйцэтгэв. Аудитын нээлтийг 2019 оны 9 дүгээр сарын 24-ны өдөр аудитын нээлтийг хийж, талбарын ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан, тайланг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хавсралт судалгаануудын хамт ҮАГ, аймгийн НДХ, ЭМД-ийн тасагт хүргүүлж ажиллав.
Хүндрэл бэрхшээл	• Олон жилийн мэдээллийг богино хугацаанд цөөн аудитор шалгаснаас ажлын болон амралтын өдрүүд илүү цагаар сууж ажилласан. • Тэтгэврийн программ нь өмнөх онд илэрсэн илүү олголтыг засаж залруулга хийгдэх боломжгүй оны эцэст бүрэн хаагддагаас аудитаар илрүүлсэн тэтгэврийг илүү олгогдсон зөрчлүүд нь дотоод хяналт

илрүүлж буцаан төлүүлсэн байгаа нь илрүүлэлтийг дахин нягтлах, тодруулахад цаг хугацаа их шаардаж байв.

- Сангуудын харилцахын журнал, орлого, зарлага нь санхүүгийн программаас бүрэн хөрвөхгүй байснаас орлого зарлагын нэгдсэн байдлаар гаргуулж судалгаа, нэгтгэл хийх боломжгүй байсан.
- Жирэмсэн, амаржсан, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг аудитаар түүвэрлэн шалгахад түүвэрт хамрагдсан тэтгэмжийн баримтыг түргэн шуурхай гаргаж үзүүлэхгүй хүлээгдэж байсан нь цаг хугацаа их шаардсан.
- ЭМД-ын сангаас санхүүжилт авдаг харилцагч байгууллагуудын бэлтгэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр нэхэмжилсэн иргэдийн нэрсийн жагсаалттай нэхэмжлэлийг ЭМД-ын тасгийн хяналтын байцаагч эмч, тасгийн дарга хянаж, баталгаажуулан мөнгө шилжүүлэхийг зөвшөөрч, санхүүд шилжүүлсэн файлыг ЭМД Сангийн өмнө хэрэглэж байсан “HIS” программ, шинээр хэрэглэж буй “HIGS” программуудаас ексел файлд хөрвүүлж авах боломжгүй байсан нь иргэдийн давхардлыг шүүж тулгалт хийхэд хүндрэл учруулсан болно

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрөөс УАГ-ын ГАГ-аас шалгасан дараах зорилтуудаас бусад зорилтын хүрээнд тус аудитыг гүйцэтгэв.

1.1.1. Тэтгэвэр болон тэтгэмжийн даатгалын шимтгэл ногдуулалтын хувь хэмжээг нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулж тогтоосон эсэх

1.1.2. Сангуудын хөрөнгийн зарцуулалтын төлөвлөлт, улсын төсвөөс олгосон татаас үндэслэлтэй байгаа эсэх

1.1.4 Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн өнөөгийн тогтолцоо нь олон улсын сайн жишигтэй уялдаж байгаа эсэх

1.1.5 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх

1.2.1 Эрүүл мэндийн даатгалын шимтгэл ногдуулалтын хувь хэмжээг нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулж тогтоосон эсэх

1.2.2 Эрүүл мэндийн даатгалын өнөөгийн тогтолцоо нь олон улсын сайн жишигтэй уялдаж байгаа эсэх

1.2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалтын төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх

1.3.1 Сангуудын хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөг үндэслэлтэй тогтоосон эсэх

1.4.1 Сангуудын чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг үр ашигтай удирдах тогтолцоо бүрдсэн эсэх

1.4.3 Сангуудын чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангасан банканд байршуулсан эсэх

1.4.4 Хуримтлалын сангийн үйл ажиллагааг үр ашигтай удирдсан эсэх

2.5.1 Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн хяналт үр дүнтэй хийгдсэн эсэх

БҮЛЭГ 1. Нийгмийн даатгалын хөрөнгийн зарцуулалтад тавих өдөр тутмын хяналтыг хангалттай түвшинд хэрэгжүүлээгүйгээс сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн хүрээнд зарцуулаагүй байна.

1.1. Нийгмийн даатгалын байгууллага нь өмнөх онуудад улсын хэмжээнд аян зарлаж иргэдийн ажилласан жилийг нийгмийн даатгалын улсын байцаагч баталгаажуулсан байгааг одоо үгүйсгэж тооцохгүй байгаа нь төрийн албаны залгамж чанар алдагдаж иргэд ажилласан жилээ дахин нотлох хүндрэл үүсч байна.

1.1.3. Баянхонгор аймгийн тэтгэврийн сангийн харилцах дансны үлдэгдэл 2012 оны эхэнд 641.8 сая, тэтгэмжийн сангийн эхний үлдэгдэл 106.4 сая төгрөг байсан бол 2018 оны жилийн эцэст тэтгэврийн сангийн харилцах дансны үлдэгдэл 698.7 сая, тэтгэмжийн сангийн харилцах дансны үлдэгдэл 56.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 1. Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /төсвийн гүйцэтгэлийн тайлангаар/ сая.төг

Харилцах дансны	2012		2013		2014		2015		2016		2017		2018	
	Тэтгэвэр	Тэтгэмж	Тэтгэвэр	Тэтгэмж	Тэтгэвэр	Тэтгэмж	Тэтгэвэр	Тэтгэмж	Тэтгэвэр	Тэтгэмж	Тэтгэвэр	Тэтгэмж	Тэтгэвэр	Тэтгэмж
Эхний үлдэгдэл	641.8	106.4	811.8	55.3	1,189.8	94.7	678.3	83.4	194.2	10.7	1.6	0.2	882.5	128.7
Эцсийн үлдэгдэл	811.8	55.3	1,189.8	94.7	678.3	83.4	194.2	10.7	1.6	0.2	882.5	128.7	698.7	56.9

Тэтгэврийн даатгалын сан.

Монгол Улсын Засгийн газраас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4¹, 30² дугаар зүйлд заасны дагуу нийгмийн даатгалын сангаас олгох болон цэргийн албан хаагчийн тэтгэврийн доод хэмжээг 2012-2018 онд 6 удаа шинэчлэн тогтоож, тэтгэврийг 5 удаа нэмэгдүүлэх шийдвэр гаргасан байна.

Хүснэгт 2. Тэтгэврийн хэмжээг өөрчилсөн шийдвэрийн судалгаа

№	Шийдвэрийн огноо дугаар	Мөрдөж эхлэх огноо	Тэтгэврийн доод хэмжээ		Тэтгэвэр нэмэгдүүлсэн хэмжээ
			Бүрэн	Хувь тэнцсэн	
1	ЗГ-ын 2010.09.15 №241	2010.10.01	105,300.0	70,200.0	Үндсэн тэтгэвэрийг 30 хувиар нэмэгдүүлсэн
2	ЗГ-ын 2012.03.16 №80	2012.02.01	140,300.0	105,200.0	Үндсэн тэтгэвэрийг 35000 төгрөгөөр нэмэгдүүлсэн
3	ЗГ-ын 2012.05.02 №153	2012.05.01	180,300.0	145,200.0	-
4	ЗГ-ын 2014.01.18 №15	2014.02.01	207,300.0	172,200.0	200.0 мянга хүртэл төгрөгийн тэтгэвэрийг 27.0 мянга, 200.0-600.0 хүртэл 22.0 мянга, 600.0 мянгаас дээш төгрөгийн тэтгэвэрийг 20.0 мянган төгрөгөөр
5	ЗГ-ын 2015.02.09 №52	2015.02.01	230,000.0	195,000.0	500.0 мянга хүртэл төгрөгийн тэтгэвэрийг 22.000, 500.0-с дээш төгрөгийн тэтгэвэрийг 20000 төгрөгөөр
6	ЗГ-ын 2016.05.31 №292	2016.06.01	251,000.0	216,000.0	Үндсэн тэтгэвэрийг 21000 төгрөгөөр нэмэгдүүлсэн
7	ЗГ-ын 2018.01.19 №16	2018.02.01	280,000.0	243,000.0	Үндсэн тэтгэвэрийг 27000 төгрөгөөр нэмэгдүүлсэн

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2012-2018 онд 191120.3 сая төгрөгийн тэтгэврийг тэтгэврийн даатгалын сангаас олгохоор төлөвлөснөөс Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т заасан тэтгэврийн төрөл тус бүрээр давхардсан тоогоор нийт 67536 тэтгэвэр авагчид 187106.9 сая, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр,

Дүрслэл 1. 2012-2018 онд олгосон тэтгэвэр /сая төгрөгөөр/



¹ Өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /цаашид "хөдөлмөрийн баталгаат хөлс" гэх/-ний 75 хувиас хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь мөн хөлсний 50 хувиас тус тус багагүй байна.

² Амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан тэтгэврийн хэмжээг өөрчлөх индексийг нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасан тэтгэврийн төрөл тус бүрээр давхардсан тоогоор 708 тэтгэвэр авагчид 3475.2 сая төгрөгийн тэтгэврийг олгосон байна.

Хүснэгт 3. Тэтгэврийн даатгалын сангийн төлөвлөгөө гүйцэтгэл

сая.төг

№	Төрөл	2012 он		2013 он		2014 он		2015 он		2016 он		2017 он		2018 он		НИЙТ	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН																	
1	Өндөр насны тэтгэвэр	13,141.8	13,101.8	14,427.6	14,516.4	17,530.5	18,050.5	20,873.4	21,288.7	23,693.8	23,300.1	24,992.6	25,129.2	29,146.3	28,784.9	143,806.0	144,171.6
2	Тахир дутуугийн тэтгэвэр	2,542.1	2,542.9	2,975.1	2,828.3	3,776.8	3,692.9	4,350.8	4,489.3	4,713.8	5,030.4	5,850.9	5,700.3	6,675.1	6,584.9	30,884.6	30,868.9
3	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1,523.0	1,459.2	1,699.4	1,545.7	1,794.0	1,664.0	2,524.4	1,789.2	1,883.6	1,831.5	1,690.2	1,825.6	1,843.2	1,951.1	12,957.9	12,066.3
4	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр	294.0	301.8	387.1	330.3	385.3	384.4	483.9	427.5	594.5	548.4	625.2	649.6	701.9	833.2	3,471.8	3,475.2
Нийт дүн		17,501.0	17,405.7	19,489.3	19,220.6	23,486.5	23,791.9	28,232.5	27,994.8	30,885.7	30,710.4	33,158.9	33,304.6	38,366.4	38,154.0	191,120.3	190,582.0

Тэтгэвэр авагчдыг дотор нь шилжилт хөдөлгөөнөөр нь авч үзвэл 2012-2018 онд 7441 иргэн шинээр тэтгэвэр тогтоолгож, 470 иргэн шилжин ирж, 793 иргэн шилжиж, нас барсан 2403 иргэний эрхийн харилцаа дуусгавар болж, тахир дутуугийн тэтгэвэр авагчийн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдсэн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн хүүхэд нь 19 насанд хүрсэн зэргээр 2350 тэтгэвэр авагчийн тэтгэвэр зогсоогдсон байна.


Хүснэгт 4. Тэтгэвэр авагчдын хөдөлгөөний судалгаа

тоогоор

№	Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	НИЙТ
1	Шинээр тогтоосон	579	551	1,795	1,090	1,015	1,128	1,283	7,441
2	Шилжин явсан	148	183	122	91	105	72	72	793
3	Шилжин ирсэн	86	88	76	52	58	57	53	470
4	Нас барсан	283	336	318	360	345	342	419	2,403
5	Зогсоогдсон	252	335	356	477	284	270	376	2,350
НИЙТ		1,348	1,493	2,667	2,070	1,807	1,869	2,203	13,457

2014 оноос шинээр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тоо өссөн үзүүлэлттэй байгаа нь “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хууль батлагдаж Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны А/57 дугаар тушаалаар “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх журам”-ыг баталж хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Дүрслэл 2. 2012-2018 онд шинээр тогтоосон тэтгэвэрийн тоо



2012-2018 онд өндөр настны тэтгэврийг 4322, тахир дутуугийн тэтгэврийг 2573, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 546 иргэн шинээр тогтоолгосноос аудитаар Баянхонгор сум, Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдыг хамруулан шинээр тогтоосон тэтгэврийн 9.6 хувь буюу 718 тэтгэврийн тогтоолтыг түүвэрлэн шалгав.

Тэтгэврийн байцаагч нар нь өндөр насны тэтгэвэр тогтоохдоо даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох цалингийн дундаж тооцуулахаар өргөдөл гаргасан хугацааны шимтгэл төлсөн цалин, хөлс түүнтэй адилтгах орлогыг зөрүүтэй тооцсоноос 5 иргэний тэтгэврийг дутуу тогтоож, нэг иргэний тэтгэврийг илүү тогтоосон зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

• Эрдэнэцогт сумын иргэн Ж.Баасанжавын өндөр насны тэтгэврийг 2015.11.02-нд тогтоохдоо 2010 оны 10 сар, 2011 оны 7 сарын цалин зөрүүтэй тооцсоноос сарын тэтгэврийг 2486 төгрөгөөр илүү тогтоож, 2019 оны 10 сар хүртэл нийт 119162 төгрөг илүү олгосон.

- Өлзийт сумын иргэн Ц.Оюуны өндөр насны тэтгэврийг 2016.08.01-д тогтоохдоо 2013 оны 05 сард давхар ажилласан 450000 төгрөгийн цалинг тооцоогүйгээс сарын тэтгэврийг 4417 төгрөгөөр дутуу тогтоож 2019 оны 10 сар хүртэл нийт 176643 төгрөг дутуу олгосон.
- Өлзийт сумын иргэн С.Батсуурийн өндөр насны тэтгэврийг 2015.07.01-д тогтоохдоо 2010 оны 10 дугаар сарын цалинг 200000 төгрөгөөр дутуу оруулж 2014 оны 6 дугаар сарын цалинг 1355000 төгрөгөөр дутуу тооцсоноос сарын тэтгэврийг 20752 төгрөгөөр дутуу тогтоож 2019 оны 10 сар хүртэл нийт 1093126 төгрөг дутуу олгосон.
- Өлзийт сумын иргэн Н.Оюуны өндөр насны тэтгэврийг 2018.09.01-д тогтоохдоо 2013 оны 12 сарын цалинг 206970 төгрөгөөр дутуу тооцсоноос сарын тэтгэврийг 2191 төгрөгөөр дутуу тогтоож 2019 оны 10 сар хүртэл нийт 30674 төгрөг дутуу олгосон.
- Баянхонгор сумын иргэн Д.Дуламдоржийн өндөр насны тэтгэврийг 2015.08.24-ны өдрөөс тогтоохдоо давхар ажил эрхэлсэн 2010 оны 08,09 сар, 2014 оны 9 сарын цалинг тус тус оруулж тооцоогүйгээс сарын тэтгэврийг 6562 төгрөгөөр дутуу тогтоож 2019 оны 10 сар хүртэл нийт 471714 төгрөг дутуу олгосон.
- Баянхонгор сумын иргэн Н.Цэцгээгийн өндөр насны тэтгэврийг 2015.02.01-ний өдрөөс тогтоохдоо 2013 оны 8 сарын цалинг зөрүүтэй тооцсоноос сарын тэтгэврийг 1584 төгрөгөөр дутуу тогтоож 2019 оны 10 сар хүртэл нийт 91872 төгрөг дутуу олгожээ.

Хүснэгт 4¹. Өндөр насны тэтгэврийг зөрүүтэй тогтоосон жагсаалт

төгрөгөөр

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ПРОГРАММААР							АУДИТААР ТООЦСОН						Зөрүү
№	Сум	Регистр	Овог	Нэр	Дундаж цалин	Сард олгох тэт	Тэтгэвэр тогтоолгосон ЦХТАО				Тооцох хувь	Тогтоох тэтгэвэр	
							Хугацаа		ЦХТАО	Дундаж			
							Эхлэх	Дуусах					
1	Эрдэнэцогт	ВП57110201	Жадамбаа	Баасанжав	467206	279154	10/1/2010	9/30/2015	27782549	463042	59.8	276668	-2486
2	Өлзийт	ВП60092409	Цамба	Оюун	1164013	685311	8/1/2012	7/30/2016	70290755	1171513	58.9	689728	4417
3	Өлзийт	ВП53091516	Сэр-Од	Батсуурь	685320	579094	7/1/2010	6/30/2015	42592623	709877	84.5	599846	20752
4	Өлзийт	ВП62102702	Нямхүү	Оюун	450674	286177	9/1/2013	8/31/2018	27247390	454123	63.5	288368	2191
5	Баянхонгор сум	ВЭ53061712	Даш	Дуламдорж	1100563	668591	8/1/2010	7/31/2015	66681859	1111364	60.8	675154	6563
6	Баянхонгор сум	ШЖ59112466	Нацаг	Цэцгээ	840553	576828	1/1/2010	12/31/2014	50571567	842859	68.6	578412	1584

Иймд тэтгэврийг зөрүүтэй тогтоож илүү олгосон 119162 төгрөгийн тэтгэврийг тэтгэвэр авагчийн тэтгэврээс суутган тооцох төлбөрийн акт тогтоож, зөрүүтэй тогтоогдсон тэтгэвэр авагчдын тэтгэврийг 2019 оны 12 дугаар сараас эхлэн шинэчлэн тогтоож олгох зөвлөмжийг аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргад хүргүүлэв.

Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2³-д заасныг зөрчиж иргэний 15 нас хүрээгүй байхдаа ажилласан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласнаар ажилласан жилд оруулан тэтгэвэр тогтоосон зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Эрдэнэцогт сумын 1957.07.01-д төрсөн иргэн Ж.Цэрэндолгорт 2012.07.01-ий өдөр өндөр насны тэтгэвэр тогтоохдоо 1971.01.01-ий өдрөөс 1972.06.30-ий өдрийг хүртэлх буюу 15 нас хүрээгүй байх 18 сарын хугацааг шимтгэл төлж ажилласан жилд оруулан шимтгэл төлсөн нийт хугацааг 20 жилээр тооцон өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоосон нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5⁴ дахь заалтыг зөрчсөн байна. Энэ талаар Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалт хариуцсан улсын байцаагч А.Мөрөнгөөс тодруулахад "...аудитын хугацаанд тус тэтгэвэр авагчийн бусад ажилласан жилүүдийг тодруулахад аймгийн Төрийн архиваас 1991 онд цалингийн мэдээлэл, 2007-2009 онд Нийтлэг үйлчилгээний албанд малчнаар ажилласан нийгмийн даатгалын дэвтэр, шимтгэл төлсөн лавлагаа гарсан нь хэвийн тэтгэвэр тогтоолгох нөхцөлийг хангасан байх тул ямар нэгэн хууль зөрчсөн болон тэтгэвэр авагчид хохирол учруулсан зүйлгүй болно" гэсэн ба энэ нь аймгийн Төрийн архивын газраас гаргасан лавлагаа, Нийгмийн даатгалын хэлтсийн лавлагаагаар нотлогдож байна.

³ "... 15 насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгөөр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно."

⁴ Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан насанд хүрсэн даатгуулагч шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.

Иймд цаашид даатгуулагчийн өндөр насны тэтгэврийг тогтоохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3⁵, Засгийн газрын 2018 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ын 3.6⁶ дахь заалтыг хэрэгжүүлж даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж байх зөвлөмжийг аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгчид хүргүүлэв.

Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хэсэгчлэн алдсан хугацаа дуусгавар болоход тэтгэврийг зогсоогоогүй зэрэг зөрчил илэрч сангаас 1.2 сая төгрөгийг тэтгэвэр авагчид илүү олгосон нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 10⁷ дугаар зүйлийг зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Эрдэнэцогт сумын тахир дутуугийн тэтгэвэр авагч 396408 хувийн хэргийн дугаартай Ж.Оюунтуяагийн хөдөлмөрийн чадвар алдалт 2014.07.13-2015.01.15-ныг хүртэл хугацаанд сэргээгдсэн байхад тахир дутуугийн тэтгэврийг зогсоогоогүйгээс 1.2 сая төгрөг илүү олгосон байна.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 -д заасны дагуу сангаас илүү олгосон 1.2 сая төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлж санд буцаан төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоов.

Аудитаар 2012-2018 онд олгосон 68244 тэтгэвэр авагчийн 190582.0 сая төгрөгийн тэтгэврийг тэтгэврийн программаас хөрвүүлэн авсан тэтгэвэр олголтын массивтай тулган шалгахад Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 6⁸ дугаар зүйлийг зөрчиж тэтгэврийг нас барснаас хойш зогсоогоогүйгээс 51 тэтгэвэр авагчид 32.4 сая төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчил илэрлээ. Тус зөрчлийг тодруулахад хэлтсийн дотоод хяналт шалгалтаар илрүүлж улсын байцаагчийн албан тоотоор 31 тэтгэвэр авагчийн 21.3 сая төгрөгийг арилжааны банкин дахь харилцах данснаас, 15 тэтгэвэр авагчийн 4.6 сая төгрөгийг тэтгэвэр авагчийн ар гэрээр нь төлүүлж, 5 тэтгэвэр авагчийн 6.5 сая төгрөгийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Сумд хооронд шилжсэн тэтгэвэр авагчийн өмнөх хувийн хэргийг программд зогсоогоогүй, тахир дутуугийн тэтгэврээс өндөр насны тэтгэвэрт шилжихэд тахир дутуугийн тэтгэврийг зогсоогоогүй, программд нэг хүний регистрийн дугаараар хоёр хувийн хэрэг үүсгэж давхар олгогдсон зэргээр 30 тэтгэвэр авагчид 16.5 сая төгрөгийн тэтгэврийг давхардуулан илүү олгосон зөрчил илэрснийг хэлтсийн дотоод хяналт шалгалтаар илрүүлж улсын байцаагчийн албан тоотоор арилжааны банкин дахь харилцах данснаас татаж төлүүлсэн байна.

Баян-Овоо сумын байцаагчаар ажиллаж байсан Ж.Ариунбуян иргэдээс сайн дурын даатгалын мөнгийг бэлнээр авсан атлаа санд орлогыг тушаагаагүй асуудал 2019 оны 6 дугаар сард илэрч, байгууллагын хяналт, шалгалт хариуцсан улсын байцаагч А.Мөрөнгоогийн хийсэн шалгалтаар 2016.11.01-ний өдрөөс 2019.05.27-ний өдрийг хүртэлх хугацаанд 26 даатгуулагчтай холбоотой 6.5 сая төгрөгийг ажилтан өөрийн эзэмшлийн Хаан, Төрийн банкны дансаар дамжуулан авсан зөрчил илэрч, хэлтсийн даргын 2019.07.29-ний өдрийн Б/27 тоот тушаал ажилтныг төрийн албанаас чөлөөлсөн байна.

Иргэдээс дансаар дамжуулан авсан даатгалын мөнгийг төлж иргэдийг одоо болтол хохиролгүй болгоогүй байгаа бөгөөд тус ажилтны 7, 8 дугаар сарын цалингийн 695.4 мянга ажилгүйдлийн тэтгэмжийн 959.5 мянга нийт 1654.9 мянган төгрөгийг олгоогүй байгаа ч санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Энэ нь сангийн дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байгаа ба нийгмийн даатгалын сан, даатгуулагч хохирох эрсдэл үүссэн тул цаашид байцаагч нарын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, банкны баталгаажуулсан хуулганд тулгуурлан

⁵ Мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 15 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.

⁶ 3.6. Даатгуулагч Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулан малчнаар ажилласан бол түүний ажилласан хугацааг 15 наснаас эхэлж тооцно.

⁷ Тахир дутуугийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нас барвал нас барсны дараагийн сар дуустал олгоно.

⁸ Өндөр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш гаргасан бол өргөдлийг даатгагч хүлээн авсан өдрөөс эхлэн, нас барсны дараагийн сар дуустал олгоно.

орлогыг тооцож ажиллах, дээрх байцаагчтай холбоотой асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.

Аудитын явцад Нийгмийн даатгалын сангаас 2019.07.24-ний өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнээс тэтгэвэр тогтоолттой холбоотой ирүүлсэн гомдлыг шалгахад “Баян-Овоо сумын “Хамтын хүч” ХХК-д ажилласан 1993 оны 08 дугаар сараас 1994 оныг дуустал хугацааны ажилласан жилийг хөдөлмөрийн дэвтэрт бичилт хийгдэж баталгаажуулсан, мөн улсын үзлэгээр баталгаажуулалт хийж нийгмийн даатгалын улсын байцаагч гарын үсэг зурж тэмдгээр баталгаажуулсан байхад тэтгэвэр тогтоохдоо ажилласан жилд оруулж тооцоогүй гэсэн гомдлыг шалгахад:

Засгийн газрын 1991 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Ажилласан хугацааг тооцох журам”-ын 1.5-д “БНМАУ”-ын хууль тогтоомжид заасан журмын дагуу хөтлөгдсөн Хөдөлмөрийн дэвтэр нь ажилласан хугацааг тооцож тогтоох үндсэн баримт болно” гэсэн заалтын дагуу иргэний 1983.07.01-ний өдөр нээсэн Хөдөлмөрийн дэвтрийн 8 дугаар хуудсанд 1994.12.31 хүртэл хугацаанд улсад ажилласан 11 жил 5 сар 15 өдрийг 045 дугаар бүхий тэмдэгтэй нийгмийн даатгалын байцаагч баталгаажуулсан байхад түүнийг авч үзээгүй, НДЕГ-ын 2010.05.31-ний өдрийн 163 тоот тушаалаар баталсан “Тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ын 3.1.4.”Иргэний 1991.07.01-нээс 1995 он хүртэл нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилласан хугацааг тооцохдоо уг иргэний ажиллаж байсан байгууллага нь цалингийн буюу хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах бусад сангаас 13.5 хувиар тооцож тэтгэврийн санд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн архиваас гаргасан лавлагааг хавсаргана” гэсэн байхад нийгмийн даатгалын хэлтэст Баян-Овоо сумын тухайн үеийн нийгмийн даатгалын баримт байхгүй гэсэн шалтгаанаар лавлагаа гаргаж өгөөгүй, тус журмын 3.1.5-д “Иргэний ажиллаж байсан байгууллага нь татан буугдсан, үндсэн баримт бичиг нь үрэгдсэн, ажилд авсан, ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэрийн он, сар, өдөр, дугаар засвартай бөгөөд энэ нь архивын үндсэн баримтаар нотлогдоогүй тохиолдолд уг хугацааг шүүхээр сэргээн тогтоолгосон шийдвэрийг хавсаргана” гэж заасны дагуу **шүүхээр тогтоолгон тооцох боломжтой байхад** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7дугаар зүйлийн 7.4⁹, 7.6¹⁰ д заасны дагуу иргэнд хууль зүйн үндэслэл бүхий хариу өгөөгүй байна.

Энэ талаар аймгийн НДХ-ийн дарга тэтгэврийн байцаагч нараас тайлбар тодруулга авахад хууль, эрхийн зүйн үндэслэл бүхий тайлбар өгөөгүй, өөрийнхөө ойлголтоор тайлбар өгсөн тул иргэдээс нийгмийн даатгалын байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хууль зүйн үндэслэл бүхий хариу өгч байх албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар иргэний тэтгэвэр тогтоолтын хувийн хэрэгт байгаа баримтууд, иргэнээс өргөдлийн хамт ирүүлсэн бусад нотлох баримтуудыг судалж үзэхэд тухайн иргэн нь 1993.07.28-нд хүүхэд төрүүлж, 1995.07.28-ныг хүртэл хүүхэд асрах чөлөөтэй байсан нь хүүхдийн төрсний гэрчилгээ, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын архивын тасгаас 2019.11.08-ний өдөр гаргасан 2445 тоот лавлагаагаар 1993-1994 онуудад “Хамтын хүч ХХК”-ийн тэтгэмжтэй, чөлөөтэй эхчүүдийн чөлөөний мөнгө олгосон цалингийн тооцооны хүснэгт, аймгийн НДХ-ээс олгосон 369830 дугаартай НДД-ийн 2 дугаар хуудсанд 1995 оны 7 дугаар сарыг дуустал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажил олгогчоос НДШ төлж баталгаажуулсан баримтаас үзэхэд нотлогдож байна.

Энэ нь БНМАУ-ын 1991 онд батлагдсан Тэтгэмжийн хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т “Иргэдийн хөдөлмөрийн чадвар алдсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж авах эрх нь улсын нийгмийн даатгалд даатгагдсан шимтгэл төлсөн нөхцөлд үүснэ”, 5 дугаар зүйлд “хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг БНМАУ-ын тэтгэвэрийн сангаас... хүүхэд асарсны тэтгэмжийг улсын төсвийн хөрөнгөөс санхүүжүүлнэ”, Засгийн газрын 1991 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Ажилласан хугацааг тооцох журам”-ын 2.и-д “төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ 2... настай болтол нь асрахаар авсан 2 удаагийн чөлөөний хугацааг ажилласан жилд хугацаанд тооцно” гэсэн

⁹ өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах;

¹⁰ өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх;

заалтуудаас харахад Д.Цэцэгмаагийн 1993 оны 07 сараас 1994.12.31-нийг хүртлэх хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг ажилласан жилд оруулж тооцох үндэслэлтэй байна.

Тус иргэн дээрх асуудлаар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөлд өргөдөл өгсөн боловч тус зөвлөлөө хуралдуулж миний өргөдлийг одоо болтол шийдвэрлэж өгөөгүй гэснийг тодруулж үзэхэд:

2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр аймгийн НДХ-ийн Гомдлын шаардлагын зөвлөлд өгсөн өргөдлийн хариуг тус зөвлөлийн нарийн бичгийн дарга болон нэг гишүүн нь өндөр насны тэтгэвэрт гарсан тул бүрэлдэхүүн бүрдэхгүй байгаа гэсэн шалтгаанаар 2019 оны 11 дүгээр сарын 14-нийг хүртэл шийдвэрлэж өгөөгүй байгаа нь Засгийн 1994 оны 171 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ажил олгогч даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан зөрөөг хянан шийдвэрлэх гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийн 14, 15 дугаар заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байх тул зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилуулж гомдлын хариуг дүрэмд заасан хугацаанд шийдвэрлэж байх шаардлагатай байна.

Тэтгэмжийн даатгалын сан.

Баянхонгор аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь тэтгэмжийн даатгалын сангаас 2012-2018 онд 8305.3 сая төгрөгийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т заасан тэтгэмжийг олгохоор төлөвлөснөөс давхардсан тоогоор нийт 12339 даатгуулагчид 8318.6 сая төгрөгийн тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас олгосноос аудитаар 3651 тэтгэмжийн олголтыг түүвэрлэн шалгав.

Дүрслэл 3.2012-2018 онд олгосон тэтгэмж /сая төг/



Хүснэгт 5. Тэтгэмжийн даатгалын сангийн төлөвлөгөө гүйцэтгэл

№	Төрөл	2012 он		2013 он		2014 он		2015 он		2016 он		2017 он		2018 он		НИЙТ	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН																	
1	ХЧТА	25.0	24.3	37.9	34.0	34.9	36.7	48.1	45.4	65.1	33.9	65.8	47.8	48.1	43.0	324.9	265.1
2	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	517.9	560.2	775.1	749.9	789.6	873.0	952.8	950.7	1,066.4	968.1	1,029.6	1,064.9	1,014.1	1,092.6	6,145.6	6,259.4
3	Оршуулгын тэтгэмж	123.0	109.8	141.9	110.1	243.3	223.5	222.6	238.0	344.0	338.7	380.0	359.0	380.0	415.0	1,834.8	1,794.1
Нийт дүн		666.0	694.3	954.9	894.0	1,067.8	1,133.2	1,223.5	1,234.1	1,475.5	1,340.7	1,475.4	1,471.7	1,442.2	1,550.6	8,305.3	8,318.6

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу давхардсан тоогоор хөдөлмөрийн чадвараа түр алдсан сайн дурын 1369 даатгуулагчид 73.0 сая, албан журмын 1904 даатгуулагчид 192.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Дүрслэл 4. Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж /сая төг/



Аудитаар хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн тогтоолт олголтыг түүвэрлэн шалгахад даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаанаас хамааран Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1¹¹ д заасан хувь хэмжээгээр, сайн дурын даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа алдсан хугацааны тэтгэмжийг бүрэн, албан журмын даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа алдсан 6 дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас хууль тогтоомжийн дагуу олгосон байна.

Жирэмсэн амаржсаны тэтгэмж:

Аудитаар жирэмсэн амаржсаны тэтгэмжийн олголтыг түүвэрлэн шалгахад даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаанаас хамааран Нийгмийн даатгалын сангаас олгох

¹¹ Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан түүний сүүлийн бүтэн ажилласан гурван сарын хөдөлмөрийн хөлснөөс дор дурдсан хувь хэмжээгээр бодож олгоно:

тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1¹², 19.2¹³-д заасны дагуу тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас сайн дурын даатгуулагчийн тэтгэмжийг 70 хувиар, албан журмын даатгуулагчийн тэтгэмжийг 100 хувиар тооцон тэтгэмжийн даатгалын сангаас хууль тогтоомжийн дагуу олгожээ.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтуудад даатгуулагчийн төрлөөс хамааран тэтгэмж бодох хувийг тооцох зохицуулалт, арга зүйг хангалттай тодорхойлж өгөөгүйгээс сайн дурын даатгалд даатгуулагч иргэн жирэмсэн, амаржсаны тэтгэмж авах сардаа аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад даатгуулагчаар бүртгүүлж нийгмийн даатгалд мэдээлснээр сайн дурын даатгуулагч, албан журмын даатгуулагчийн ангилалд шилснээр тэтгэмж бодох хувь хэмжээ нэмэгдэж авах нөхцөлийг бүрдсэн байхад үүнийг тусгайлсан журам, аргачлалаар зохицуулж өгөөгүй байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

Сайн дурын даатгалд даатгуулагч иргэн Б.Бямбасүрэн нь 2016.03.17-нд жирэмсний тэтгэмж авсан ба 2016 оны 01 сар хүртэл сайн дурын даатгалд хамрагдан даатгуулж байсан ба 2016 оны 02 дугаар сард “Эй Ви Эс Эф-ХИЛХЯЗ /малын эмч/ АГР ТГ” /НДХ-ийн лавлагаа мэдээллийн программд тухайн нэрээр орсон/ гэсэн байгууллагаас нийгмийн даатгалд цалин мэдээлж орсноос, тэтгэмжийг цалингийн дунджийн 100 хувиар тооцуулан авсан ба тэтгэмж авсны дараагийн сараас сайн дурын даатгалаар даатгуулсан байна.

Иймд Жирэмсэн амаржсаны тэтгэмж авах даатгуулагчийн тэтгэмжийн хувь хэмжээг тооцох, бодох, олгох аргачлалыг бүрэн зохицуулсан журмыг баталж хэрэгжүүлэх зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлэв.

Оршуулгын тэтгэмж:

Баянхонгор аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу нийт 2658 иргэнд 1794.1 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж олгосон байна.

Оршуулгын тэтгэмжийн хэмжээг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 21¹⁴ дүгээр зүйлд заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2009 оны 18 дугаар тогтоолоор 300,0 мянга, 2013 оны 26 дугаар тогтоолоор 2014.01.01-ний өдрөөс эхлэн 620,0 мянга, 2016 оны 16 дугаар тогтоолоор 2016.06.01-ний өдрөөс эхлэн 1,0 сая төгрөгөөр тус тус тогтоож мөрдүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Оршуулгын тэтгэмж олгохдоо тэтгэмж авагч нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.2¹⁵-д заасан хугацаанаас хойш материалаа нийгмийн даатгалын байгууллагад ирүүлсэн байхад 0.3 сая төгрөгийн тэтгэмжийг даатгуулагчид олгосон зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор сумын 2012.06.12-д нас барсан даатгуулагч Б.Дуламсүрэнгийн материалыг 2014.04.02-д ирүүлсэн ч оршуулгын зардалд 0.3 сая төгрөгийг 2014.04.03-д буюу нас барснаас 656 хоногийн дараа олгосон.

Иймд хуульд заасан хугацааг баримтлаагүйгээр олгосон тэтгэмжийн 0.3 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2¹⁶-д заасны дагуу холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэх төлбөрийн актыг тогтоож Нийгмийн даатгалын хэлтсийн даргад хүргүүлэв.

¹² Тэтгэмжийн даатгалд даатгуулж шимтгэл төлсөн хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг болон төрийн албан хаагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгоно.

¹³ Тэтгэмжийн даатгалд сайн дураар даатгуулсан эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 70 хувиар тооцож 4 сарын хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгоно.

¹⁴ Оршуулгын тэтгэмжийн хэмжээг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

¹⁵ 24.4.Тэтгэмж авах өргөдөл, хуульд заасан холбогдох баримт бичгийг дор дурдсан хугацаанд бүрдүүлж нийгмийн даатгалын байгууллагад өгнө: 24.4.2. оршуулгын тэтгэмж авах иргэн даатгуулагчийг нас барснаас хойш 4 долоо хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 6 сарын дотор.

¹⁶ 2.Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны алдаагаар буруу олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг гэм буруутай албан тушаалтан хариуцна.

1.1.6. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг өдөр тутамдаа үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс зөрчил дутагдал арилахгүй давтагдан гарсаар байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт, олголтод 2012-2018 онд НДЕГ, аймгийн МХГ, Төрийн аудитын газар болон хэлтсийн дотоод хяналт шалгалтаар тэтгэврийн даатгалын санд 297.4 сая, тэтгэмжийн даатгалын санд 0.6 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж нийт 298.1 сая төгрөгийн 393 төлбөрийн акт тогтоож зөрчлийг барагдуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Хүснэгт 6. 2014-2018 онд хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчлийн судалгаа

сая.төг

Хүснэгт 6: 2014-2018 онд хяналт шалгалтаар илрүүлсэн төлсөр зорилгын судалгаа														
№	Хяналт шалгалт хийсэн байгууллагын нэр	Тэтгэвэр						Тэтгэмж					НИЙТ	
		2013	2014	2015	2016	2017	2018	2014	2015	2016	2017	2018	Тэтгэвэр	Тэтгэмж
1	НДЕГ		69.0	-	27.6	-	12.0	-	-	-	-	-	108.6	-
2	Хэлтсийн дотоод хяналт шалгалтаар	27.0	33.3	26.2	22.8	36.1	19.2	-	-	-	0.4	0.3	164.6	0.6
3	Төрийн аудит		4.1	-	-	-	-	-	-	-	-	-	4.1	-
4	Мэргэжлийн хяналтын газар		20.2	-	-	-	-	-	-	-	-	-	20.2	-
НИЙТ			126.6	26.2	50.4	36.1	31.1	-	-	-	0.4	0.3	297.4	0.6

Хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчлийн барагдуулалтыг шалгахад нийт төлбөр зөрчлийн 94.6 хувийг бүрэн барагдуулж, 5.3 хувийг дутуу, 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт огт барагдаагүй байна.

Хүснэгт 6. Төлбөр зөрчлийн барагдуулалт

сая.төг

Үзүүлэлт		Бүрэн барагдуулсан	Дутуу хэрэгжсэн		Огт хэрэгжээгүй
			70-с дээш хувь биелсэн	70 хүртэл хувь биелсэн	
Төлбөрийн актын	Тоо	386	1	5	1
	Дүн	281.9	2.9	12.8	0.5
Эзлэх хувь		94.6%	1.0%	4.3%	0.2%

Бүрэн барагдуулаагүй төлбөрийн актаас 13.1 сая төгрөгийн 5 төлбөрийн актын хариуцагчийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн бол 2014 онд тогтоосон 3.0 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байгаа тул 2019.12.01-ний дотор төлбөрийг актыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх зөвлөмжийг Нийгмийн даатгалын хэлтсийн даргад хүргүүлэв.

1.2 Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олгохдоо НДҮЗ-ийн баталсан журмыг зөрчиж, өвчтөний хэвтэн эмчлүүлсэн хугацаанд хийгдсэн шинжилгээ, оношилгооны төлбөр, зарим өвчтөний эмчилгээний зардлыг давхардуулан илүү олгосон байна.

1.2.4. Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 344 тоот тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, орон нутагт эрүүл мэндийн даатгалын тасаг гэсэн бүтцээр зохион байгуулагдаж, Баянхонгор аймгийн ЭМД-ын тасаг нь тасгийн дарга, улсын байцаагч-хяналтын эмч гэсэн 2 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.1.2, 9 дүгээр зүйлийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас аймгийн Нэгдсэн эмнэлэг, Жаргалант, Баянцагаан, Богд сумдын Сум дундын эмнэлэг, хувийн хэвшлийн 6 эмнэлэг, 19 сум, Шаргалжуут тосгоны эмийн эргэлтийн сан, аймгийн төвийн 6 хувийн хэвшлийн эмийн сангуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтэд 2012-2018 онд нийт 31217.4 сая төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 8. ЭМ-ийн тусламж үйлчилгээний төлөвлөгөө гүйцэтгэл

/сая.төг/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Нийт
Батлагдсан төсөв	2,847.4	3,150.1	4,683.1	4,848.1	5,452.5	5,765.2	5,550.6	32,297.0
Гүйцэтгэл	2,910.7	2,953.9	4,648.4	4,619.8	5,272.2	5,547.2	5,265.2	31,217.4
Хэтрэлт, хэмнэлт	63.3	(196.2)	(34.7)	(228.3)	(180.3)	(218.0)	(285.4)	(1,079.6)

Улсын эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг, Богд, Баянцагаан, Жаргалант сумдын Сум дундын эмнэлгүүд нь Эрүүл мэндийн тухай хуулийн 9.2 дахь заалтын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд зориулж 2012-2018 онд 19976.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 20284.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 9. Улсын эмнэлэгт олгосон ЭМ-ийн туслам үйлчилгээний төлөвлөгөө гүйцэтгэл /сая.төг/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Нийт
Батлагдсан төсөв	1,910.0	2,007.2	3,055.8	3,069.3	3,241.8	3,329.0	3,363.8	19,976.9
Гүйцэтгэл	2,158.4	2,007.0	3,059.9	3,069.2	3,241.6	3,385.3	3,362.8	20,284.2
Хэтрэлт, хэмнэлт	248.4	(0.2)	4.1	(0.1)	(0.2)	56.3	(1.0)	307.3

Тухайн хугацаанд улсын эмнэлгүүд нь батлагдсан төсвийг 2012 онд 248,4 сая, 2017 онд 56,3 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсныг өмнөх оны харилцахын үлдэгдлээс зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын хэлтэс нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийг холбогдох хууль, журмын дагуу нэхэмжлэлийн дагуу олгож иржээ.

Аудитаар Нэгдсэн эмнэлэгт 2016-2018 онд хэвтэн эмчлүүлэгсдийн нэрсийг, тухайн хугацаанд оношилгоо, шинжилгээнд хамрагдсан даатгуулагчдын нэрстэй тулган давхардлыг шалгахад зарим зардлыг давхардуулан нэхэмжилсэн байхад санхүүжилт олгосон зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн иргэдийн санхүүжилтийг олгохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан 2016 оны 19 дүгээр тогтоолын 4.6.7-д "Хэвтүүлэн эмчлэх хугацаанд тухайн эмнэлэгт үзүүлсэн амбулаторийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас давхардуулан олгохгүй", 4.7.4-т "Хэвтүүлэн эмчлэх хугацаанд тухайн эмнэлэгт хийгдсэн суурь оношилгоо, шинжилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас давхардуулан олгохгүй" гэж заасан заалтыг зөрчиж, 28.7 сая төгрөгийг давхардуулан илүү шилжүүлсэн, мөн 2 иргэний хэвтэн эмчлүүлсэн хугацааны төлбөр 0,5 сая төгрөгийг давхардуулж шилжүүлсэн зөрчил илэрсэн тул нийт 29.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Эрүүл мэндийн даатгалын сангаас дараалсан 3 жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ аваагүй даатгуулагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах заалт эрүүл мэндийн тухай хуучин хуульд байсан бөгөөд 2015 оноос хасагдсан байна. Гэвч 2012-2014 онд энэ заалтыг хангасан иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулаагүй байна.

Рашаан сувиллын зардал

Магадлан итгэмжлэгдсэн Шаргалжуут рашаан сувилалд сувилуулсан даатгуулагчид нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.1.2, 13.1.1 заалт болон НДҮЗ-ийн баталсан холбогдох журмын дагуу сангаас 110.0 мянган төгрөгийг олгохоор тогтоосон бөгөөд 2012-2018 онд ЭМДС-ийн сангаас даатгуулагчийн сувиллын зардалд 4665.9 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 4631.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 10. Рашаанд сувилалд олгосон ЭМ-ийн туслам үйлчилгээний төлөвлөгөө гүйцэтгэл /сая.төг/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Нийт
Батлагдсан төсөв	348.5	357.4	792.0	792.0	792.0	792.0	792.0	4,665.9
Гүйцэтгэл	348.5	357.4	792.0	660.0	890.0	792.0	792.0	4,631.9
Хэтрэлт, хэмнэлт	-	-	-	(132.0)	98.0	-	-	(34.0)

Аудитаар сангийн зарцуулалтыг шалгахад жил бүр аймгийн хэмжээнд сум бүрээс 20-30 ахмад настныг хамруулж, жилд 1-2 удаа нэгдсэн зохион байгуулалтаар Шаргалжуут рашаан сувилалд амруулсан байна.

Дээрх амрагчдын рашаан сувиллын зардлын 110.0 мянган төгрөгийг журмын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас, мөн аймгийн Халамжийн сангаас Ахмад настны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т "эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох" гэсэн заалтын дагуу /2016-2018 онд нэг амрагчийн зардлын 50 хувь буюу дунджаар 129.6 -184.0 мянган төгрөг олгожээ/ ахмад

настанд олгохоор байхад нэхэмжлэлийн дагуу Шаргалжуут рашаан сувиллын дансанд шилжүүлсэн байна.

Үүнийг холбогдох ажилтнуудаас тодруулахад ахмад настан амрагч нь амралтын төлбөр төлөх боломжгүйгээс бид төлбөрийг ЭМДСан, Халамжийн сангаас хуулийн холбогдох заалтын дагуу нэхэмжилж авсан гэсэн тайлбар өгсөн болно.

Аудитын илрүүлэлт

Ахмад настны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т "эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох" гэсэн заалтын хүрээнд мэдээлэлд ойрхон ахмадууд жил бүр амарч, хөнгөлөлт эдэлж байхад зарим ахмадууд энэ хөнгөлөлтийг эдэлж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл нэгдсэн зохион байгуулалтаар рашаан сувилалд амарсан ахмадууд дээрх хөнгөлөлтийг зохих хэмжээнд эдэлж, Халамжийн сангаас хөнгөлөлтийн зардлаа рашаан сувиллын дансанд шилжүүлсэн байна.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг рашаан сувилалд амруулахдаа жирийн даатгуулагч иргэний нэгэн адил төлбөр төлүүлж амруулсны дараа Ахмад настны тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн иргэний тухай хуулийн холбогдох заалтын дагуу Халамжийн сангаас хөнгөлөлтийг олгох байтал, Шаргалжуут рашаан сувилалд нэгдсэн зохион байгуулалтаар амарсан ахмадууд төлбөр төлөөгүй байхад Халамжийн сангаас санхүүжилт олгож байгаа нь хуульд нийцэхгүй байна.

Аудитаар дээрх үйл ажиллагааг ахмад настануудад төрөөс үзүүлж байгаа халамжийн үйлчилгээ мөн гэж үзэж байгаа боловч "зохион байгуулалттайгаар олон ахмадуудыг хамруулж, төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулсан байна" гэж дүгнэхэд хүргэж байгаа тул энэ талаарх саналыг УАГ-т хүргүүлж байна.

Хувийн хэвшлийн эмнэлэг

Баянхонгор аймагт "Баян-Энэрэл" ХХК, "Бургатай" ХХК, "Мандал баян булаг" ХХК, "Нар бад" ХХК, "Шинэ төв" ХХК, "Шинэ хүн" ХХК гэсэн хувийн хэвшлийн 6 эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хувийн эмнэлгийн үйлчилгээний зардалд 2012-2018 онд нийт 3861.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3039.7 сая төгрөгийг ЭМ-ын тусламж үйлчилгээний төлбөрт олгосон байна.

Хүснэгт 11. Хувийн хэвшлийн эмнэлэгт олгосон ЭМ-ийн тусламж үйлчилгээний төлөвлөгөө гүйцэтгэл /сая.төг/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Нийт
Батлагдсан төсөв	457.0	473.3	463.1	504.6	606.6	755.8	600.9	3,861.3
Гүйцэтгэл	272.6	297.8	455.9	474.0	471.5	533.7	534.2	3,039.7
Хэтрэлт, хэмнэлт	(184.4)	(175.5)	(7.2)	(30.6)	(135.1)	(222.1)	(66.7)	(821.6)

Дээрх хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 2012-2018 онд жилд дунджаар 372-520 хүн хэвтэн эмчлүүлсэн байна.

Хүснэгт 12. Хэвтэн эмчлүүлэгсдийн судалгаа

№	Эмнэлгийн нэр	Тухай жилд хэвтэж эмчлүүлсэн хүний дундаж тоо						
		2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	Баян-Энэрэл ХХК	355	386	367	393	402	400	461
2	Бургатай ХХК	345	353	316	357	342	341	337
3	Мандал баянбулаг ХХК	750	757	795	800	787	817	804
4	Нар бад ХХК	403	430	390	398	442	456	553
5	Шинэ төв ХХК	382	406	444	465	469	483	517
6	Шинэ хүн ХХК	0	0	230	476	469	444	450
Хувийн эмнэлгийн дундаж		372	389	423	481	485	490	520

Аудитын явцад авсан санал асуулгаар 2018 онд ЭМДС-ийн зардлыг аймгийн ЭМД-ийн тасгаар олгож эхэлснээс хойш эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг хугацаанд нь олгохгүй, дараа сарын 20-ний өдрөөс хойш олгох болсон нь хувийн эмнэлгүүдийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна гэжээ.

Үүнийг тодруулан шалгахад 2017 онд тухайн сарын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэхэмжлэлийг тухайн сарын 20-ны дотор хянаж, санхүүжилтийг тухайн сард нь багтааж олгож байсан бол 2018 оноос нэхэмжилсэн санхүүжилтийг дараа сарын 20-ний өдрөөс хойш олгож ирсэн байна. Энэ нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас 2017

онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний 4.14¹⁷, 5.1¹⁸, 2018 онд ЭМДЕГ-тай байгуулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний 5.8-т “Даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэхдээ батлагдсан төсвийн сарын хуваарьт багтаан төлбөрийн тооцоог ЭМДМ2 маягтын дагуу гарган өвчний түүх, бусад холбогдох бүртгэл, анхан шатны маягтын хамт **сар бүрийн 15, 31-ний өдрөөр тасалбар болгож**, тасалбар болгосон өдрөөс хойш **ажлын 3** өдрийн дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр эрүүл мэндийн байгууллагад ирүүлнэ” гэж заасан байна. Эндээс харахад 2017 онд сардаа нэг удаа сар бүрийн 20-нд нэхэмжлэл аваад, сардаа багтааж санхүүжилт олгохоор, 2018 онд сар 2 удаа нэхэмжлэл авч санхүүжилтийг олгохоор заасан байхад 2018 онд гэрээний нөхцөлөө мөрдөөгүйгээс сарын эцэст нэг удаа нэхэмжлэл хүлээн авснаас шалтгаалан санхүүжилтийг сард нь олгох боломжгүй болсон байна.

Аудитын илрүүлэлт:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын санхүүжилтийг тухайн сард нь олгоогүйгээс хувийн эмнэлгүүд ажиллагсдынхаа цалин олгох, нийгмийн даатгалын шимтгэл төлөх зэрэг үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Жишээ болгож аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй 1 хувийн эмнэлгийн 2017, 2018 оны санхүүжилт олгосон байдлыг харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 13.2017, 2018 онд санхүүжилт олгосон байдлыг харьцуулсан судалгаа								сая.төг
2017 он				2018 он				
Нэхэмжилсэн		санхүүжилт олгосон		Нэхэмжилсэн		санхүүжилт олгосон		
огноо	дүн	огноо	дүн	огноо	дүн	огноо	дүн	
2017.01.20	10.2	17/01/30	10.2	2018.01.26	10.7	2018.02.13	8.4	
2017.02.20	11.5	17/02/23	11.5	2018.02.23	9.4	2018.03.02	8.4	
2017.03.23	8.8	17/03/30	8.8	2018.03.30	13.2	2018.03.15	10.6	
-	-	-	-	-	-	2018.04.11	5.9	
-	-	-	-	-	33.3	-	33.3	
2017.04.20	12.7	17/04/24	12.7	2018.04.27	11.8	2018.05.08	8.4	
2017.05.29	11.6	17/05/30	11.6	2018.05.31	12.6	2018.05.14	3.4	
-	-	-	-	-	-	2018.06.11	12.6	
2017.06.20	11.1	17/06/30	11.1	2018.06.26	8.8	2018.06.29	8.8	
-	-	-	-	-	33.2	-	33.2	
2017.07.20	11.1	17/07/26	11.1	2018.07.31	14.6	2018.08.14	14.6	
2017.08.21	11.0	17/08/23	11.0	2018.08.28	12.1	2018.09.13	12.1	
2017.09.18	10.9	17/09/18	10.9	2018.09.28	4.7	2018.10.11	4.7	
2017.10.24	10.9	17/10/24	9.0	2018.10.29	11.6	2018.11.16	11.6	
-	-	17/10/31	1.9	2018.11.29	14.3	2018.12.13	14.3	
2017.11.23	11.0	17/11/27	10.5	2018.12.18	11.2	2018.12.31	11.2	
-	-	17/11/29	0.5	-	-	-	-	
2017.12.05	10.4	-	-	-	-	-	-	
2017.12.19	0.8	17/12/20	11.2	-	-	-	-	
Дүн	132.0		132.0		134.9		134.9	

Иймд хувийн хэвшлийн эмнэлэгтэй байгуулсан гэрээнд заасны дагуу сард 2 удаа нэхэмжилсэн нэхэмжлэлийн дагуу санхүүжилтийг хугацаа алдалгүй түргэн шуурхай олгох зөвлөмжийг аймгийн ЭМД-ийн тасгийн даргад зөвлөмж хүргүүлж, ҮАГ-аар дамжуулан ЭМДЕГ-т санал хүргүүлэв.

1.2.5 ЭМД-ийн сангаас иргэдэд хөнгөлөлттэй үнээр эм олгох, түүнд хяналт тавих ажлыг улсын хэмжээнд цахим хэлбэрт шилжүүлж, Эрүүл мэндийн байгууллага, эмийн сангуудын харилцан уялдаа бүхий санхүүгийн программыг шинэчлэн сайжруулж ашигласнаар хөнгөлөлттэй эмийн зарцуулалтад тавих хяналт сайжирсан байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.10¹⁹ дахь заалтын хүрээнд хөнгөлөлттэй эмийн үнийн жагсаалт, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталж, мөрдөн ажилласан байна. Тухайлбал: Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2013 оны 28, 2015 оны 23, 2016 оны 08, 18, 2018 оны 10, 24-р тогтоол тус тус батлагдаж гарсан бөгөөд одоогийн байдлаар 2018.12.27-ны 24 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллаж байна.

¹⁷ “Даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэхдээ тухай сарын төлбөрийн тооцоог ЭМДМ2 хүснэгтийн дагуу гарган өвчний түүх, кассын тасалбарын хамт сар бүрийн 20-ны өдрөөр тасалбар болгож, тасалбар болгосон өдрөөс хойш 3 хоногийн дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ”.

¹⁸ “Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын нэхэмжлэл, жагсаалтын холбогдох баримт бичгийн хамт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан нягтлан хянаж, төлбөрийг шилжүүлнэ”

¹⁹ Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох

ЭМД-ийн сангаас 2012-2018 онуудад 3792.0 сая төгрөг олгохоор төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3274.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, батлагдсан төсөв 517.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Хүснэгт 14. ЭМД-ын сангаас олгосон эмийн хөнгөлөлтийн зардал.

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Нийт
Батлагдсан төсөв	131.9	312.2	372.2	482.2	812.1	888.4	793.0	3,792.0
Гүйцэтгэл	131.9	291.1	353.6	416.6	669.0	836.2	576.2	3,274.6
Хэтрэлт, хэмнэлт	-	(21.1)	(18.6)	(65.6)	(143.1)	(52.2)	(216.8)	(517.4)

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй эмийн үнийн хөнгөлөлтийн батлагдсан төсөв 2012 оноос бусад онуудад 21.1-216.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Сумдын эргэлтийн эмийн сан, эмийн хөнгөлөлт үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий эмийн сангуудтай жил бүр гэрээ байгуулан, ЭМД-ын сангаас иргэдэд хөнгөлөлтэй үнээр олгох эмийн зардалд аймгийн НДХ-ийн ЭМД-ын сангаас 2012-2017 онд 2999.0 сая төгрөг олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 2698.4 сая төгрөгийг олгосон байна.

2018 онд ЭМД-ын тасгаас 793.0 сая төгрөг олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 576.2 сая төгрөг олгосон байна. Үүний шалтгааныг аймгийн Эрүүл мэндийн тасгийн дарга /А.Цэрмаа/-аас тодруулахад “Жил бүрийн батлагдсан төсвөөс эмийн сангуудын төсөв гүйцэтгэлээр хэмнэлт мэт харагдаж байгаа боловч бодит байдал дээр даатгуулагчид хөнгөлөлттэй эмээ авч уух хэрэгцээ шаардлага байсаар л байна. ЭМД-ын системд өмнө хэрэглэж байсан “HIS” программ нь тухайн эмийн сан нь жилдээ хэдэн төгрөгийн төсөвтэй, хэдэн төгрөгийн гүйцэтгэл авч байгааг тухай бүр хянах боломжгүй байсан бол ЭМД-ын сан бие даан үйл ажиллагаа явуулж “HIGS” цахим программ нэвтрүүлэн ажилласнаар ямар газраас хэдэн удаа нийт хэдэн төгрөгийн тусламж үйлчилгээ авсан зэрэг нь харагддаг, хянагддаг болсон байна. Аймгийн төвийн эмийн сан нь сар бүрийн 20-ноор сарын батлагдсан төсөв дуусаж гүйцэтгэлээ ирүүлж байхад, хөдөө сумдын зарим эмийн сангууд, төсвийн 50-60 хувьтай тэнцэх гүйцэтгэл гаргаж ирүүлсэн зэрэгтэй холбоотой” гэсэн тайлбар ирүүлсэн болно.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээг жил бүр НДХ, ЭМД-ын тасаг хууль, журмын дагуу дүгнэсэн байгаа ба 2018 оны гэрээг дүгнэхдээ улсын болон хувийн эмнэлгүүд, Шаргалжуут рашаан сувиллын үйл ажиллагааг 100 онооны 17 нэгж асуудлаар, эмийн сангуудын үйл ажиллагааг 100 онооны 18 нэгж асуудлаар ажил дүгнэх комиссын өгсөн онооны дунджаар үнэлж, дүгнэжээ.

1.2.6 Улсын хэмжээнд 2018 онд цахим систем нэвтрүүлэн шинэчилж, HIGS цахим программыг нэвтрүүлэн ажилласнаар цахим жороос гадна Нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлэг, сувилал, элэгний В,С вирусийн илрүүлэг, 0-12 насны хүүхдийн шүдний үзлэг, урьдчилан сэргийлэх нас насны багцын оношилгоо шинжилгээ зэргийг ямар газраас хэдэн удаа нийт хэдэн төгрөгийн тусламж үйлчилгээ авсан зэрэг нь харагддаг, хянагддаг болж, хөнгөлөлттэй эмийн зарцуулалтад тавих хяналт сайжирсан байна.

ЭМД-ын сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад 2012-2018 онд НДЕГ болон аймгийн Төрийн аудитын газар, аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалтыг хийж, 2014 онд НДЕГ-аас хийсэн хяналт шалгалтаар 6.6 сая, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн аудитаар 12.7, нийт 19.3 сая төгрөгийн зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

ЭМДЕГ-аас 2018 оны 05 дугаар сард хувийн эмнэлгүүдэд тухайн өдөр хэвтэн эмчлүүлж буй иргэдийн өвчний түүх болон өмнөх хугацаанд хэвтэн эмчлүүлэгсдийн өвчний түүхээс 10-12 материалыг түүвэрлэн шалгаж, өвчний түүхийг түгээмэл үйлдлийн стандартын дагуу бичиж хэвшсэн, үйл ажиллагаа нь стандартын дагуу явагдаж, анхан шатны болон санхүүгийн баримт эмх, цэгцтэй зөрчилгүй, аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй эмийн сангуудын эм хангамж 85,0 хувьтай, үйлчлүүлэгч олонтой хэвийн ажиллаж байна гэж дүгнэсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймгийн ЭМД-ын тасгийн 2018 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж санхүүжилт олгож буй байгууллагуудтай тооцоо нийлэхдээ өглөг, авлагын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөлгүйгээр акт үйлддэг зэрэг зөрчил илрүүлж, зөрчлийг цаашид анхаарч ажиллах зөвлөмж өгснийг 2019 онд программд сайжруулалт хийж зөрчлийг арилгасан байна.

1.3. Ажилгүйдлийн тэтгэмж тогтоох арга зүйг ажилгүйдлийн тэтгэмж олгох журамд тодорхой зохицуулж өгөөгүйгээс иргэдэд сангаас олгох тэтгэмжийг харилцан адилгүй олгосон байна.

1.3.2. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журмын заалтыг мөрдөөгүйгээс ажилгүйдлийн тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон, ҮОМШӨД-ын сангаас тэтгэврийн даатгалын шимтгэлийг улирал бүр үнэн зөв тооцож шилжүүлээгүй байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан.

ҮОМШӨД-ын сангаас 2012-2018 онд 714.4 сая төгрөгийг олгохоор батлагдаж, гүйцэтгэлээр 612.7 сая төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 15. ҮОМШӨД-ийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 15. ҮОМШӨД-ийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл															сая.төг		
№	Төрөл	2012 он		2013 он		2014 он		2015 он		2016 он		2017 он		2018 он		НИЙТ	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
ҮОМШӨД-ЫН САН																	
1	Тахир дутуугийн тэтгэвэр	59.7	51.0	62.5	55.6	68.8	56.3	59.5	63.4	84.1	67.5	68.0	66.6	69.6	70.7	472.1	431.1
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	25.0	21.4	31.5	24.1	34.6	25.8	28.1	22.1	23.5	21.1	21.0	17.7	18.1	20.9	181.8	153.1
3	Бусад зардал	6.6	2.1	8.7	3.8	11.1	0.3	8.8	8.5	8.9	3.5	8.3	8.3	8.1	2.0	60.5	28.5
Нийт дүн		91.3	74.5	102.7	83.5	114.4	82.3	96.4	94.0	116.5	92.1	97.3	92.6	95.9	93.7	714.4	612.7

ҮОМШӨД-ын сангийн 2012-2018 онд зарцуулсан 612.7 сая төгрөгийн зарцуулалтыг авч үзвэл 431.1 сая төгрөгийг тахир дутуугийн тэтгэвэрт, 153.1 сая төгрөгийг тэжээгчээ алдсан тэтгэвэрт, 2.3 сая төгрөгийг ХЧТА-ны тэтгэмжид, 6.3 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээх зардалд, 0.5 сая төгрөгийг сувилалд амрагчийн унааны зардалд, 19.1 сая төгрөгийг тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын зардалд тус тус зарцуулсан байна.

Дүрслэл 5. ҮОМШӨД-ийн сангийн зарцуулалт /2012-2018 он/



ҮОМШӨД-ын сангийн нийт зардлын 70.4 хувийг тахир дутуугийн тэтгэвэрт, 25.0 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулсан байна.

ҮОМШӨД-ын сангаас тэтгэвэр авагчийн тоо харьцангуй тогтвортой байсан ба аудитын явцад аймгийн МХГ-аас үйлдвэрлэлийн осолд орсон иргэдийн судалгааг авч судлахад үйлдвэрлэлийн ослоор нас барсан, хүнд гэмтсэн зарим иргэд тус сангаас тэтгэвэр тогтоолгоогүй байна.

Хүснэгт 16. ҮОМШӨД-ийн сангаас тэтгэвэр авагчийн тоо

№	Төрөл	сая.төг						
		2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	Тахир дутуугийн тэтгэвэр	18.0	18.0	18.0	18.0	18.0	16.0	18.0
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	8.0	9.0	7.0	7.0	6.0	5.0	6.0
Нийт дүн		26.0	27.0	25.0	25.0	24.0	21.0	24.0

Тус сангаас олгох хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг жил бүр 0.5-0.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2013 онд 5 иргэнд 1.3 сая, 2016 онд 3 иргэнд 1.0 сая, нийт 2.3 сая төгрөгийг олгосон байна.

Хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээх зардалд тус онуудад 1.0-3.0 сая төгрөгийг олгохоор төлөвлөж, протезийн хөнгөлөлтөд 2015 онд 1 иргэнд 5.0 сая, 2017 онд 1 иргэнд 1.3 сая, нийт 6.3 сая төгрөгийг анхан шатны баримтад үндэслэн олгожээ.

ҮОМШӨД-ын сангаас тэтгэвэр авагчийн сувиллын зардалд 2012 онд 1.0 сая, 2014 онд 1.5 сая, бусад онуудад 1.0 сая төгрөгөөр баталж, сувилуулсан иргэдийн замын зардлын баримтыг үндэслэн 2015-2018 онд 0.5 сая төгрөгийг олгожээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5²⁰, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2008 оны 20 дугаар тогтоолын 1²¹ дэх заалт, НДЕГ-ын даргын 2009.04.07-ны өдрийн 131 тоот тушаалын хавсралтаар “ҮОМШӨД-ийн сангаас тэтгэврийн даатгалын шимтгэл тооцох, төлбөр хийх, тайлагнах журам”-ын 2-т заасны дагуу жил бүрийн төсвийн хуваарьт 4.1-6.0 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлэх шимтгэлийн зардалд төлөвлөж, зардлыг улирлаар хуваарилсан байна.

Холбогдох хууль, журмын дагуу 2012-2018 онд тус сангаас тэтгэврийн даатгалын санд нийт 19.1 сая төгрөгийг шилжүүлснийг аудитаар шалгахад зөрүүтэй, улирлаар зардлыг баталж өгсөн байхад тухайн улиралдаа багтааж зардлыг тооцож шилжүүлээгүй байгаа бөгөөд 2014 онд тус зардлыг 6.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байхад зардлыг тооцож төлөөгүй байгаа нь НДЕГ-ын даргын 2009 оны 131 тоот тушаалын хавсралтаар баталсан “ҮОМШӨД-ийн сангаас тэтгэврийн даатгалын шимтгэл тооцох, төлбөр хийх, тайлагнах журам”-ын 3²²-т заасныг зөрчсөн байна.

Аудитын явцад ҮОМШӨД-ын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авсан иргэдээр тооцож, тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тухайн үед мөрдөгдөж байсан

Хүснэгт 17.ҮОМШӨД-ийн сангаас тэтгэврийн даатгалын санд төлөх шимтгэлийн зардлыг тооцсон түүвэр

Он	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГААР					АУДИТААР ТООЦСОН	ЗӨРҮҮ
	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	ДҮН		
2012	-	1.00	-	1.14	2.14	2.14	-
2013	0.56	0.56	-	1.32	2.44	2.51	(0.07)
2014	-	-	-	-	-	2.88	(2.88)
2015	0.96	-	1.69	0.81	3.46	2.51	0.94
2016	0.85	0.77	0.73	-	2.34	2.74	(0.40)
2017	-	0.60	0.95	5.24	6.79	3.63	3.16
2018	-	-	0.98	0.98	1.96	3.48	(1.52)
Дүн					19.13	19.89	(0.76)

тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувиар тооцоход 2012 оноос бусад онд зардлыг зөв тооцож шилжүүлээгүй байна. Иймд илүү тооцож, тэтгэврийн даатгалын санд шилжүүлсэн 0.8 сая төгрөгийг 2019 оны зардлаас суутган тооцох төлбөрийн актыг тогтоов.

Тус аудитаар ҮОМШӨД-ийн сангаас тэтгэвэр авагч иргэдийн мэдээллийг нийгмийн даатгалын лавлагааны программаас шалгахад

хөдөлмөр эрхэлж байгаа зарим иргэдийг 01 /аж ахуйн нэгж байгууллагын ажилтан/ кодоор мэдээлсэн байгаа тул цаашид 22 /тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа ажилтан/ кодоор мэдээлэхийг зөвлөмж болгов.

Тус сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхээр хуульд заасан бөгөөд Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2008 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “ҮОМШӨД-ын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”-ын 2.1²³-д заасан зардлыг аймгийн нийгмийн даатгалын сангийн төсөвт батлаагүй байна. Харин 2016, 2018 онд НДЕГ-тай гэрээ байгуулсан “Форумланд” ХХК, 2017 онд “Уул уурхай хүний нөөцийн хөгжил” ТББ-аас хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг аймагт зохион байгуулж, НДЕГ-аас санхүүжүүлсэн нийт 26.8 сая төгрөгийг олгосон байна.

Ажилгүйдлийн даатгалын сан:

Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгохдоо 1994 онд батлагдсан “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль”, Засгийн газраас 1997 онд баталсан “Ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг зарцуулах журам” болон НДҮЗ-өөс

²⁰ “ҮОМШӨД-ийн сангаасүйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг санхүүжүүлнэ”

²¹ “ҮОМШӨД-ын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчийн уг тэтгэврийг авч байх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан даатгуулагчийн төлбөл зохих хувиар тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, ҮОМШӨД-ын сангаас тэтгэврийн даатгалын санд төлж байхаар тогтоосугай”

²² НДҮЗ-ийн тогтоолоор батлагдсан нарийвчилсан хуваарийн дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгагдсан хэмжээ, тэтгэвэр авагчдын тоог тусгасан санхүүгийн тайланг баримтлан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн данснаас энэ журмын 2 дахь хэсэгт заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тэтгэврийн даатгалын сангийн дансанд шилжүүлж, төлбөрийн гүйцэтгэлийг нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын тайланд тусгана”

²³ 2.1 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, урьдчилан сэргийлэхтэй холбоотой сурталчилгаанд зарцуулах зардлын хэмжээ нь тухайн жилийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн шимтгэлийн орлогын 0,5 хувиас хэтрэхгүй байна”

2014 онд баталсан 10, 2015 онд баталсан 11, 2016 оны 22 тоот тогтоолоор баталсан журам, тухайн жилд НДЕГ-аас гаргасан зөвлөмж, аргачлалуудыг мөрдөж ажилласан байна.

Тус сангаас 2012-2018 онд 2085.1 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгохоор төлөвлөснөөс иргэний харьяаллын дагуу ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт, өргөдөл гаргасан 1720 даатгуулагчид 1915.9 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг олгосон байна.

Хүснэгт 18. Ажилгүйдлийн даатгалын сангийн зарцуулалт									/сая төг/
Он	Ажилгүйдлийн тэтгэмж			Сургалтын зардал			Нийт		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо
2012	283.1	161.3	201	0.3	0	0	283.4	161.3	201.0
2013	308.4	304.4	308	0.6	0.0	0.0	309.0	304.4	308.0
2014	150.0	143.1	158	0.9	0.0	0.0	150.9	143.1	158.0
2015	267.7	259.6	275	3.4	0.0	0.0	271.1	259.6	275.0
2016	281.3	278.5	272	0.0	0.0	0.0	281.3	278.5	272.0
2017	421.4	467.4	253	0.0	0.0	0.0	421.4	467.4	253.0
2018	373.2	301.6	253	0.0	0.0	0.0	373.2	301.6	253.0
Нийт	2085.1	1915.9	1720	5.2	0.0	0.0	2090.3	1915.9	1720

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2018 онд олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг аудитад 100% хамруулж, бусад онд олгосон тэтгэмжийг түүврийн арга ашиглаж, тэтгэмж тогтоолтын хуудас, анхан шатны баримтыг нийгмийн даатгалын лавлагааны программд тулгалт хийж шалгав.

Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас 2013 онд олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг 2014 онд УАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн “Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар үзсэн болно.

Аудитаар даатгуулагч ажлаас чөлөөлөгдөж, ажил олгогчтой тооцоо хийж дууссаны дараа Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.2 дахь заалтын дагуу ажилгүй болсноо оршин суугаа нутаг дэвсгэрийн Хөдөлмөрийн болон Нийгмийн даатгалын байгууллагад 14 хоногийн дотор бүртгүүлж, ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл гаргахдаа бүрдүүлэх материалын жагсаалтад ажилгүй болсноо Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн хуудас байх ёстой байтал түүнийг ажилгүйдлийн тэтгэмж хариуцсан байцаагч авч хувийн хэрэгт хавсаргаагүй, тэтгэмж тогтоолтын хуудсанд тэтгэмж бодсон байцаагч, хянасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулаагүй зөрчилтэй байгаа тул цаашид хувийн хэргийн бүрдэлт, баталгаажуулалтад анхаарч ажиллахыг зөвлөв.

Ажилгүйдлийн тэтгэмжийг олгохдоо тэтгэмж хариуцсан байцаагч солигдох бүрт сүүлийн 3 сарын цалинг өөр өөрөөр авсан, халагдсан сарын цалинг зарим онд оруулж тооцсон, зарим онд оруулж тооцоогүйгээс харилцан адилгүйгээр тооцож олгосон, тэтгэмж олгох дундаж цалинг буруу тооцсон, даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон тохиолдолд НД-ын байгууллагад мэдэгдэж, тэтгэмжээ зогсоолгоогүй, ажилд орсон даатгуулагчийн цалинг нөхөн төлүүлэхдээ зөрүүтэй тооцоолсон, хууль хяналтын байгууллагаар ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн мэдээлсэн атлаа ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчаар нөхөн төлүүлээгүй зэрэг зөрчил илэрлээ.Тухайлбал:

Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж авсан атлаа ажилд орсон 2 даатгуулагчийн 331.9 мянган төгрөгийн тэтгэмжийг нөхөн төлүүлээгүй байгаа нь НДҮЗ-ийн 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 22 тоот тогтоолоор батлагдсан “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ын 5.6²⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

²⁴ “Тэтгэмж авагч нь ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон, тэтгэмж авах хугацаа дуусгавар болсон бол энэ тухайгаа нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэн, тэтгэмж олголтыг зогсоож, тооцоо хийж, нийгмийн даатгалын дэвтрээ буцаан авна. Түр ажилд орж, дахин ажлаас халагдсан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж авах өмнө тогтоосон хугацаа дуусаагүй бол энэ журмын 5.2.2, 5.2.3-т заасан бичиг баримтыг бүрдүүлэн Нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлж, ажилгүйдлийн тэтгэмжээ үргэлжлүүлэн авах, эсэх асуудлыг шийдвэрлүүлэх”

Аудитын илрүүлэлт

- 300459 тоот хувийн хэрэг бүхий даатгуулагч нь 2014.01.09 өдөр ажлаас халагдаж, 2014.02.02-ноос 2014.05.19-ний өдрийг хүртэлх хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж авсан атлаа 2014.05.08-ний өдөр ажилд орсон /нийгмийн даатгалын дэвтрийн бичилтээс ажилд орсон огноог тодруулсан/ байхад цалинтай давхацсан 7 хоногийн тэтгэмжийн 244.8 мянган төгрөгийг төлүүлээгүй;
- 302082 тоот хувийн хэрэг бүхий даатгуулагч 2018.10.22-ний өдөр ажлаас халагдаж, 2018.10.24-нөөс 2019.02.14-ний өдрийг хүртэлх хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж авсан атлаа 2019.02.02-ний өдөр ажилд орсон байхад цалинтай давхацсан 7 хоногийн тэтгэмжийн 86.8 мянган төгрөгийг төлүүлээгүй байгаа тул тус тус нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Ажилгүйдлийн тэтгэмж авсан хугацаанд ажилд орсон даатгуулагчийн ажилд орсон өдрөөс хойших хугацааны тэтгэмжийг нөхөн төлүүлэхдээ хоногийг зөрүүтэй тооцсон зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2016-2018 онуудад олгосон 6 даатгуулагчийн 507.4 мянган төгрөгийг дутуу төлүүлж, 5 даатгуулагчийн 264.6 мянган төгрөгийн илүү төлүүлж дээрх журмын 5.6 дахь заалтыг зөрчсөн тул 507.4 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх, илүү төлсөн 264.6 мянган төгрөгийг даатгуулагчид буцаан олгохоор төлбөрийн акт тогтоов.

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1²⁵ дэх заалтыг зөрчиж, даатгуулагчид 306.5 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байгаа тул нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аудитын илрүүлэлт

302101 тоот хувийн хэрэг бүхий даатгуулагч нь 2018.10.31-ний өдөр тушаал гарч ажлаас чөлөөлөгдөж, аймгийн НДХ-т 2018.11.13-ний өдөр өргөдлөө гаргаж, 2018.11.14-ний өдрөөс 2019.03.05-ний өдөр хүртэлх хугацаанд тэтгэмж авах эрх үүсч, 1379.5 мянган төгрөгийн тэтгэмж авсан байна. Тус даатгуулагч 2018.11.19-ний өдөр ажилд буцаан томилогдсон тул тэтгэмжийн зөрүүг санд буцаан төлүүлэхдээ халагдсаны маргааш өдрөөс тооцож олгосон байгаа нь хуульд нийцэхгүй байна.

Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч хууль хяналтын байгууллагаар ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийг нөхөн гаргуулах шийдвэрийг Шүүхээс тогтоосны дагуу ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгож, нийгмийн даатгалын мэдээллийн баазад 32 /хууль бусаар ажлаас зайлуулагдсан, мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн/ кодоор цалинг мэдээлсэн байхад 2 даатгуулагчид олгосон 4532.6 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлүүлж тооцоо хийгээгүй байгаа нь журмын 4.6²⁶-т заасныг зөрчсөн зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоов.

Аудитын илрүүлэлт

- 301101 тоот хувийн хэрэг бүхий даатгуулагч нь 2016.02.29-ний өдөр ажлаас халагдаж, 2017.03.04-нөөс 2018.06.21-ны өдрийг хүртэлх хугацаанд 3317.8 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авсан ба шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийг буруутай этгээдээр төлүүлж, нийгмийн даатгалын мэдээллийн баазад 2016 оны 03 дугаар сараас 2017 оны 03 дугаар сар хүртэлх хугацааны цалинг 32 кодоор мэдээлсэн байхад ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлөөгүй;
- 301834 тоот хувийн хэрэг бүхий даатгуулагч нь 2017.10.11 өдөр ажлаас халагдаж, 2017.11.04-нөөс 2018.02.22-ны өдрийг хүртэлх хугацаанд 1214.8 мянган төгрөгийн ажилгүйдлийн даатгал тэтгэмж авсан ба шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийг буруутай этгээдээр төлүүлж, нийгмийн даатгалын мэдээллийн баазад 2017 оны 11 дүгээр сараас 2018 оны 09 дүгээр сар хүртэлх хугацааны цалинг 32 кодоор мэдээлсэн байхад ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлөөгүй байна.

²⁵ “Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрийн хугацаанд олгоно”

²⁶ “Даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдсаныг шүүхээс тогтоож, түүний ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгож, ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож зохих санд төлсөн тохиолдолд тухайн даатгуулагчийн ажилгүй байх хугацаанд авсан ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлүүлж, тооцоо хийнэ”

Дээрх 2 даатгуулагчийн нэг нь аймгийн НДХ-т ажиллаж байсан ба ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлөөгүй шалтгааныг тодруулахад “32 кодоор цалинг нөхөн мэдээлүүлэхэд ажилгүйдлийн даатгалын санд тэтгэмж төлөхгүй тул би уг санд хохирол учруулаагүй” гэсэн тайлбар хийж байгаа бөгөөд 32 кодоор мэдээлэгдсэн цалингийн хувь хэмжээг НДҮЗ-ийн 2016 оны 22 тоот тогтоолоор баталсан “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ын 4.6 дахь заалттай нийцүүлэн өөрчлөх нь зүйтэй байна. Иймд ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийг нөхөн мэдээлэх 32 кодыг журамд нийцүүлэн өөрчилж, нөхөн мэдээлсэн ажилгүй байсан хугацааны цалингаас ажилгүйдлийн тэтгэмжийг суутган тооцдог байх саналыг ҮАГ-аар дамжуулан НДҮЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын илрүүлэлт

Аудитын явцад аймгийн ШШГГ-аар дамжуулан ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн төлүүлсэн иргэдийн судалгааг авч судлахад 5 иргэн ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлсөн байхад 7 иргэн 15.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг буцаан төлөөгүй байна.

Дээрх 7 иргэний 5 иргэн нь нийгмийн даатгалд цалинг нөхөн мэдээлээгүй, цалингаас НДШ-ийг төлүүлээгүй байгаа ба харин 2 иргэн нь нийгмийн даатгалын байгууллагад цалингийн мэдээллийг хүргүүлж, 32 кодоор цалинг мэдээлсэн байна. Тухайлбал: 2016.10.18-ний өдрөөс 2017.02.06-ны өдрийг хүртэлх хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч 2016 оны 11 дүгээр сараас 2018 оны 04 дүгээр сар хүртэлх хугацааны ажилгүй байсан нийт 18 сарын цалинг 32 кодоор 2018.12.01-ний өдөр нөхөн мэдээлсэн байгаа тул нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2017.05.12-ны өдрөөс 2017.09.05-ны өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч 2017 оны 5 дугаар сараас 2017 оны 12 дугаар сар хүртэлх хугацааны ажилгүй байсан нийт 8 сарын цалинг 2018.12.01-ний өдөр нөхөн мэдээлсэн байгаа бөгөөд тус даатгуулагч нь буцаж ажилд ороогүй байна.

Даатгуулагчийн цалинг 32 кодоор мэдээлэхдээ хяналт шалгалт хариуцсан улсын байцаагчаар хянуулж, сангаас олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг буцаан төлүүлж санг хохиролгүй болгосны дараа шимтгэлийг нөхөн мэдээлээгүй байгаа нь ажиллагсдын хариуцлагагүй байдал, НДХ-ийн ажиллагсдын ажлын уялдаа сул байгаатай холбоотой байна.

2017.05.24-ний өдрөөс 2017.09.15-нийг хүртэлх хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч нь шүүхийн шийдвэрээр 2017.05.18-ны өдрөөс 2017.10.16-ний өдрийг хүртэлх ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн мэдээлүүлж 2017.12.22-ний өдөр ажилд томилогдсон байгаа тул ажилгүйдлийн тэтгэмж, цалин давхацсан ажлын 27 өдрийн 414.7 мянган төгрөгийг даатгуулагчаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Бусад даатгуулагчдын хувьд ажилд эргэн томилогдоогүй байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 3²⁷, 7²⁸, 9.3²⁹ гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас зарим иргэдийн тэтгэмжийг бөөнд нь нэг удаа олгосон байхад зарим иргэний тэтгэмжийг тэтгэмж авах хугацаа дууссаны дараа олгосон байна. Иймд цаашид журмыг баримталж, даатгуулагч бүр ижил тэгш хандах, даатгуулагчдын нийгмийн даатгалын дэвтрийг тэтгэмж авч байх хугацаанд нь олгохгүй байх, ажилд орж, 107 хоног тооцсон тохиолдолд журмын 5.6-т заасны дагуу холбогдох баримт материалыг бүрдүүлж, хувийн хэрэгт хавсаргах шаардлагатай байгаа тул холбогдох байцаагч нарт энэ талаар зөвлөв.

Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам, түүнийг дагалдан гарсан аргачлалд зарим заалтыг тодорхой болгож, Нийгмийн даатгалын тухай хуульд заасан “Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, **ажилгүй болоход өөрт нь**, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий

²⁷ “Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дундажаас ... тогтоосон хувиар тооцож олгоно”

²⁸ ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллага сард 2 удаа тооцож олгоно

²⁹ даатгуулагч энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар болон бусад хэлбэрээр түр ажил хөдөлмөр эрхэлсэн бол түүний тэтгэмжийг түдгэлзүүлэн зогсоож, тэтгэмж олгох хугацааг уг хөдөлмөр гүйцэтгэсэн хоногоор сунгана”

нийгэм эдийн засгийн арга хэмжээ мөн” гэж заасантай нийцүүлж, даатгуулагчийн ажилгүй байх хугацааны эрсдэлийг хамгаалах нь зүйтэй байна. Үүнд:

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1³⁰-т ажилгүйдлийн тэтгэмжийг сүүлийн 3 сараар бодохоор заасан бөгөөд 2014 онд НДҮЗ-өөс баталсан 10 дугаар тогтоолын 3.1-т ажилласан хугацааг харгалзан **бүтэн** ажилласан сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцож олгохоор зааж өгснийг өөрчилж, бүтэн ажилласан гэсэн үгийг хасаж өөрчлөлт хийснээс тэтгэмжийн байцаагч нар дундаж цалин бодох сарыг өөр өөрийн аргаар харилцан адилгүй сонгон тооцож, бага цалин авсны дараа ажлаас халагдсан даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж бага бодогдож даатгуулагчид хохиролтой хууль, тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Харьцуулсан жишээ

- Ажлаас 2017.02.01-нд чөлөөлөгдсөн даатгуулагчийн дундаж цалинг бодохдоо 2017 оны 1, 2016 оны 12, 11 сарын цалингаар тооцохоор байхад 2017 оны 1 дүгээр сарын 78.0 мянган төгрөгийн цалинг орхиж, өмнөх 2016 оны 10,11,12 дугаар сарын цалингаар цалингийн дунджийг тооцсон байхад 2017.10.09-нд халагдсан даатгуулагчийн дундаж цалинг бодохдоо өмнөх 9 дүгээр сарын цалин 155.1 мянган төгрөг байхад тус сарыг оруулж 9,8,7 сараар дундаж цалинг тооцсон;
- Ажлаас 2018.12.11-нд ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчийн дундаж цалинг бодохдоо өмнөх 11 сарын 125.9 мянган төгрөгийг орхиж өмнөх 10,9,8 сарын цалингаар дундаж цалинг тооцсон байхад 2018.10.31-ний өдөр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчийн дундаж цалинг тооцохдоо 06 дугаар сарын 38.0 мянган төгрөгийн цалинг оруулж тооцсон байна.

Дээрх жишээнүүдээс харахад журамд нарийвчлан заагаагүйгээс зарим даатгуулагчийн тэтгэмжийг өндөр олгохын тулд бага цалинтай сарыг алгасаж, даатгуулагч бүрт харилцан адилгүй хандсан харагдаж байна.

Мөн ажилгүйдлийн тэтгэмжийг авах өмнөх 3 сард ээлжийн амралттай сар таарсан тохиолдолд зарим байцаагч 2 сарын дунджаар тооцож тухайн сарын дундаж цалинг гаргасан, зарим байцаагч нягтлан бодогчоос тодруулга авсан гэх боловч түүнийг албажуулаагүй атлаа цалинг бууруулж авсан, зарим даатгуулагчийн амралттай сарыг тодруулахгүйгээр хасч бодсон зэргээр харилцан адилгүйгээр тэтгэмжийг тооцсон байна.

Даатгуулагчийн амралттай байх хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсийг нягтлан бодогч нийгмийн даатгалд зөв мэдээлээгүйгээс ээлжийн амралт авсны дараагийн саруудад ажлаас чөлөөлөгдөж тэтгэмж авсан даатгуулагчийн 3 сарын дундаж цалин хөлс зөрүүтэй тооцоологдсоноос даатгуулагч бага тэтгэмж авах эрсдэлтэй байгаа ба үүнд ялангуяа боловсролын салбарт ажиллагсдын ээлжийн амралтын хоног ажлын 30-48 хоног байдгаас шалтгаалж дундаж цалин буруу тооцоологдсон байна. Тухайлбал:

Харьцуулсан жишээ

- 2016.10.03-нд ажлаас чөлөөлөгдсөн Заг сумын дунд сургуулийн ажилтны дундаж цалин тооцохдоо амралттай байх хугацааны 7,8 дугаар сарыг алгасаж, 5,6,9 дүгээр саруудын цалингаар дундаж цалинг тооцсон;
- 2018.10.01-ний өдрөөр ажлаас чөлөөлөгдсөн Баянговь сумын Цэцэрлэгийн ажилтны дундаж цалинг тооцохдоо 9.8.7 сараар авч, 7 сарын цалин 218.6 мянган төгрөг гарсныг өмнөх 6 сарын цалинтай дундажлан, 393.4 мянган төгрөгөөр тооцсон байна.

Аудитын илрүүлэлт

- 2018.11.16-ний өдөр ажлаас халагдсан Номундалай цогцолбор сургуулийн ажилтны дундаж цалин тооцохдоо 8,9,10 дугаар сарын цалингаар тооцсон бөгөөд 8 дугаар сарын цалинг нягтлан бодогч мэдээлэхдээ ээлжийн амралтын нөхөн олговроос 8 дугаар сард ногдуулсан олговрыг тооцож мэдээлээгүйгээс, тус ажилтны 8 дугаар сарын цалин 112,9 мянган төгрөгийг дундаж цалинд оруулж тооцсон байна.

Аудитын явцад тухайн байгууллагаас дээрх ажилтны ээлжийн амралтад ногдох 48 хоногийн нөхөн олговрыг 7,8,9 саруудад ногдох дүнгээр гаргуулахад 8 дугаар сард 19 хоногийн амралтын нөхөн олговрын 867.0 мянган төгрөгийг 6,7 сард хувааж мэдээлсэн

³⁰ “Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дор дурдсан хувь хэмжээгээр тооцож олгоно”

байна. Байгууллагын нягтлан бодогч амралтын нөхөн олговрыг нийгмийн даатгалд зөв мэдээлээгүй, шимтгэл хариуцсан байцаагч түүнийг шалгаж хүлээн аваагүй, тэтгэмж хариуцсан байцаагч амралтын сарын цалинг байгууллагын нягтлан бодогчоос тодруулж тэтгэмжийг бодоогүйгээс тухайн даатгуулагчид 327.2 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг дутуу олгосон байгаа тул нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Дээрх жишээнүүдээс харахад байгууллагын нягтлан бодогч ажилтны ээлжийн амралтын нөхөн олговрыг амралтын хоногт ногдохоор тооцож, Нийгмийн даатгалын хэлтэст үнэн зөв мэдээлээгүйгээс ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж бодоход хохиролтой байгаа тул цаашид ээлжийн амралттай сарын цалинг үнэн зөв мэдээлж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулж, нийгмийн даатгалын тайланд ажиллагсдын цалин үнэн зөв мэдээлэх талаар ААН, байгууллагуудын нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Аудитын явцад хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагч нь ажлаас халагдахын өмнөх 3 сарын цалинг өндрөөр мэдээлж, ажилгүйдлийн тэтгэмж авсан тохиолдлууд илэрлээ. Тухайлбал:

- Худалдааны үндэсний сургуулийн ажилтан 2014 оны 1-5 дугаар сарын цалинг сар бүр 700.0 мянган төгрөгөөр мэдээлж, 6-8 дугаар сарын цалин 1000.0 мянган төгрөгөөр мэдээлж, 2014.09.02-ны өдөр ажлаас чөлөөлөгдөж, тэтгэмж авсан ба ажилгүйдлийн тэтгэмжийн хугацаа 2014.12.29 өдөр дууссан бөгөөд 2015 оны 1 дүгээр сараас эхлэн өмнөх ажилд эргэн орж, цалинг 602.5 мянган төгрөгөөр мэдээлсэн байна.
- “Очир заан” ХХК-ний ажилтан 2018 оны 3 дугаар сараас өмнөх цалинг 600.0 мянган төгрөгөөр мэдээлж, 4,5,6 дугаар сарын цалин 1500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн мэдээлж, 2018 оны 7 дугаар сард ажлаас чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмж авч, эргэж ажилдаа орж, цалинг 600.0 мянган төгрөгөөр мэдээлсэн байна.

Иймд ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжийг өндөр авахын тулд цалинг зохиомлоор өсгөх эрсдэлийг бууруулах зорилгоор ажилгүйдлийн тэтгэмж олгох дундаж цалинг бодохдоо сүүлийн 3 сарын цалингийн дундаж хэмжээг өөрчлөлт хийх шаардлага бий болсон ба багадаа сүүлийн 6 сарын дунджаар бодох нь зүйтэй байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох сургалтын зардлын хэмжээг Засгийн газрын 2001 оны 137 тоот тогтоолоор ажилгүйдлийн даатгалын сангаас зарцуулах сургалтын зардлыг нэг хүнд ногдох дээд хэмжээг 50.0 мянган төгрөгөөр тогтоож, үүнээс дахин шинэчлэн тогтоогоогүй байгаа бөгөөд сургалтын зардалд 2012-2015 онд 5.2 сая төгрөг батлагдсан боловч гүйцэтгэлээр зардал олгоогүй байна.

1.3.3. НДЕГ, байгууллагын дотоод хяналт, аймгийн МХГ, СХАА-наас хийсэн хяналт шалгалтаар ҮОМШӨД-ийн сангийн зарцуулалтад зөрчил илрээгүй байна. Харин аймгийн Төрийн аудитын газраас 2014 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар ҮОМШӨДС-аас тэтгэвэр авагч 2 иргэнд тэтгэврийг давхардуулан олгосон атлаа дараа сард нь суутган тооцоо хийгээгүй, ҮОМШӨД-ын сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч иргэнд тэтгэвэр илүү олгосон зэрэг зөрчилд 2.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн хяналт шалгалтаар даатгуулагч ажилгүй байх эрх үүсэж тэтгэмж авах хугацаандаа ажилд орсонтой холбоотой 2013-2018 онд 99 даатгуулагчид олгосон 69.6 сая төгрөгийн тэтгэмжийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосноос 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 9 даатгуулагчтай холбоотой 4.9 сая төгрөгийн төлбөрийн акт барагдаагүй авлагын үлдэгдлээр байна.

№	Байгууллага	2013	2014	2015	2016	2017	2018	Нийт
1	УНДЕГ		4.9				0.3	5.2
2	Төрийн аудитын газар		5.8			2.1		7.9
3	МХГ, СХАА		0.1	6.0				6.1
4	Дотоод хяналт	9.2	7.4	0.9	9.1	4.6	19.2	50.4
	Нийт	9.2	18.2	6.9	9.1	6.7	19.5	69.6

Тус сангийн зарцуулалтад 2013-2018 онд тогтоосон төлбөрийн актын 72.2 хувь буюу 50.4 сая төгрөгийн байгууллагын дотоод хяналтаар тогтоосноос харахад сангийн зарцуулалтад тавих дотоод хяналт сайн хэрэгжиж байгаа ч зөрчлийг барагдуулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй байгаа тул барагдаагүй төлбөрийн актыг хуулийн байгууллагад шилжүүлэх зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлэв.

1.4. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд 2012-2018 онд арилжааны банкнуудад байршуулсан харилцах дансны хүүгийн орлогыг 265.5 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь тус аймагт үйл ажиллагаа явуулж буй ХААН, Голомт, ХАС, Капитал, Төрийн банкны удирдлагатай, жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулан, сангуудын харилцах дансны чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд жилийн 5.5 хувийн хүү тооцож ажилласан байна.

Аймгийн Нийгмийн даатгалын сангуудын чөлөөт мөнгөн хөрөнгийг арилжааны банкны хадгаламжийн дансанд байршуулаагүй, Төрийн сан, арилжааны банкин дахь харилцах дансанд байршуулж гүйлгээ хийж буй харилцах дансны үлдэгдэл хүүг гэрээнд заасан нөхцөлөөр тооцон олгосон байна.

Нийгмийн даатгалын сангуудын харилцах дансны чөлөөт мөнгөн үлдэгдлийн хүүгийн орлогоор 2012-2018 онд 265.5 сая төгрөгийн орлого орсноор санхүүгийн тайланд тусгасан ба аудитын явцад Монгол банкнаас Нийгмийн даатгалын сангуудын арилжааны банкнуудад байршуулсан харилцах дансны чөлөөлт үлдэгдэлд тооцсон хүүгийн судалгааг гаргуулж авахаар албан тоотоор хандсан боловч Төв банкны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасантай нийцэхгүй тул гаргаж өгөх боломжгүй гэсэн албан тоот өгч гаргаж өгөөгүй тул харилцахын хуулгатай тулган баталгаажуулаагүй болно.

Хүснэгт 20. Сангуудын харилцах дансны жилийн хүүгийн орлого

Сангийн төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	сая.төг 2018
Тэтгэвэрийн даатгал	15.6	30.9	25.8	12.6	14.4	27.4	49.1
Тэтгэмжийн даатгал	2.2	2.9	3.0	1.9	2.3	2.7	4.1
ҮОМШӨний даатгал	1.0	1.1	5.3	3.4	1.4	0.7	0.6
Эрүүл мэндийн даатгал	9.4	6.6	5.6	4.9	4.6	7.8	3.2
Ажилгүйдлийн даатгал	1.5	1.3	3.7	2.2	2.1	1.3	2.8
Дүн	29.7	42.9	43.3	25.0	24.8	39.9	59.9

1.5. Нийгмийн даатгалын хэлтэс нь он дамжсан НДШ-ийн авлагын үлдэгдэл ихтэй байхад авлагыг барагдуулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллаагүй байна.

1.5.1. НДЕГ-аас 2006 оны “Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталж, мөрдөж ирсэн бөгөөд тус бодлогын баримт бичгийн 3.2.1.4-т авлагын бүртгэлийг тусгах талаар заасан байна.

Тус бодлогын баримт бичигт улсын НДЕГ-ийн системийн нэгдсэн санхүүгийн тайланд НДШ-ийн авлагын үлдэгдлийг бодитой тайлагнах, олон улсын байгууллагын тавьж байгаа шаардлагыг хангах зорилгоор НДЕГ-ийн түвшинд найдваргүй авлагын нөөцийн сан байгуулж, нягтлан бодох бүртгэлд тусгана гэж заасан боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар НДС-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 427.3 сая төгрөгийн авлагатай гарсан бөгөөд нийт авлагын 90.3 хувь буюу 385.9 сая төгрөг нь даатгуулагчаас авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байгаа бөгөөд авлагыг бууруулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллаагүй байна.

Хүснэгт 21. НДС-ийн авлагын судалгаа

сая төг

№	Авлагын нэр төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	105.3	134.7	301.8	732.3	622.9	276.8	385.9
2	Нийгмийн даатгалын актын авлага	0.1	0.2	0.1	6.2	0.1	0.2	-
3	Нийгмийн даатгалын алдангийн авлага	-	0.1	0.1	4.0	0.4	-	-
4	Улсын төсвийн авлага -ЭМД	145.8	107.0	90.7	83.6	116.2	141.6	-
5	Эмнэлгүүдэд олгосон урьдчилгаа	49.7	49.7	49.7	49.7	49.7	49.7	-
6	Сувиллуудад олгосон урьдчилгаа	-	-	16.8	-	-	-	-
7	Бусад авлага	65.0	36.3	68.8	42.3	45.1	47.3	41.4
ДҮН		365.9	327.9	527.9	918.0	834.3	515.6	427.3

Аудитаар хийсэн судалгаанаас харахад нийт ажил олгогчийн 17-34 хувь нь оны эцэст НДС-ийн өглөгтэй гарсан бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын ихэнх хувийг 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий авлага эзэлж байна.

Хүснэгт 22. НДС-ийн авлагын үлдэгдлийн судалгаа

сая.төг

Он	Нийт ААН, байгууллагын тоо	Авлагатай байгууллагын тоо	Авлагын дүн	1000.0 мянган төгрөг хүртэлх			1001.0-5000.0 мянган төгрөг хүртэлх			5001.0 мянган төгрөгөөс дээш		
				Байгууллагын тоо	Авлагын дүн	Эзлэх хувь	Байгууллагын тоо	Авлагын дүн	Эзлэх хувь	Байгууллагын тоо	Авлагын дүн	Эзлэх хувь
2012	508	88	105,325.60	74	13,578.46	12.9	13	30,494.07	29.0	1	61,253.07	58.2
2013	553	79	134,742.50	69	4,782.40	3.5	9	18,439.30	13.7	1	111,520.84	82.8
2014	624	105	301,828.90	72	18,305.78	6.1	24	44,926.57	14.9	9	238,596.50	79.1
2015	660	229	732,299.90	164	43,953.90	6.0	47	115,732.01	15.8	18	572,614.00	78.2
2016	706	217	622,873.40	167	30,847.74	5.0	38	93,151.00	15.0	12	498,874.70	80.1
2017	758	247	276,778.90	187	34,466.35	12.5	41	93,262.57	33.7	19	149,050.00	53.9
2018	778	170	385,907.90	109	28,633.28	7.4	39	93,885.79	24.3	22	263,388.86	68.3

Нийт авлагын дотор 100.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий авлагыг судлахад Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг дэвсгэрт байрлах “Хүүш” уурхайн алтны шороон ордыг ашиглан үйл ажиллагаа явуулж байсан “Рео Баянхонгор” ХХК-ийн 2013 онд 317 даатгуулагчийн 111.5 сая, 2014 онд 347 даатгуулагчийн 157.4 сая, 2015 онд 326 даатгуулагчийн 386.3 сая, 2016 онд 114 даатгуулагчийн 402.7 сая төгрөгийн авлагатай гарсан нь сангийн авлага өндөр гарах үндсэн шалтгаан болсон байгаа ба тус компани 2017 онд авлагыг төлж барагдуулсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг насжилтаар нь авч үзэхэд 91 хоногоос дээш хугацаатай авлага нийт авлагын дунджаар 58.1 хувийг эзэлж байгаа нь авлагыг тухай бүр нь барагдуулаагүй байхад Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1³¹, 16.3³², 20 дугаар зүйлийн 20.1.2³³, 20.1.4³⁴ дэх заалтыг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээ авч, хариуцлага тооцож ажиллаагүй байна./Судалгаа хавсралт №1/

Азийн хөгжлийн банкны хүрээнд 2018 онд “Интер аудит” ХХК-тай хамтран “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн гаргасан боловч мөрдөж эхлээгүй байна. Тус бодлогын баримт бичигт найдваргүй авлагын үлдэгдлийг УСНББОУС-ын дагуу цэвэр боломжит үнэ цэнээр үнэн зөв, бодитой тайлагнах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-тай нийцсэн байдлаар санхүүгийн тайланг бэлтгэхийн тулд найдваргүй авлагын нөөц санг байгуулж, нягтлан бодох бүртгэлд тусгана, нөөц санг байгуулахдаа НДХ, газраас ирүүлэх НДС-ийн авлагын насжилтын тайланд үндэслэнэ гэж заажээ. Найдваргүй авлагын нөөцийг ямар аргаар хэдэн хувиар

³¹ 1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ.

³² Хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сарын төлөх шимтгэлийг дараа сарын 5-ны дотор төлсөн байна. Шимтгэл төлөх, тайлагнах эцсийн хугацаа нийгмийн даатгалын төрөл бүрт нэг адил байна. Хэрэв энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхцавал дараагийн ажлын өдөр шимтгэлийг төлж тайлагнана.

³³ “дутуу төлөгдсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлж, шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,3 хувийн алданги ногдуулна. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна”

³⁴ “энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн, даатгуулагчид нийгмийн даатгалын дэвтэр нээж баталгаажуулаагүй, уг зөрчлийн улмаас даатгуулагчийн эрх ашгийг хохироосон албан тушаалтныг 10000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна”

байгуулах, дансанд хэрхэн тусгах журмыг НДҮЗ-ийн шийдвэрээр баталж мөрдөнө гэж заасан бөгөөд НДҮЗ-өөс 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдөр “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам”-ыг баталсан байна.

Хяналт шалгалтаар илэрч тогтоосон төлбөрийн актыг санхүүгийн тайланд авлагаар тусгадаггүй байсныг 2018 онд НДЕГ-аас ирсэн шалгалтын зөвлөмжийн дагуу актыг санхүүгийн тайланд авлагаар тусгасан бөгөөд ийнхүү тусгахдаа төлбөрийг актыг тогтоосон дүнгээр бүртгэлгүй, дансанд тушаасны дараа авлагаар бүртгэж хаасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1³⁵, 14 дүгээр зүйлийн 14.4.2³⁶ заалтыг зөрчсөн байна. Иймд цаашид хяналт шалгалтаар тогтоосон төлбөрийн актыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгэж, авлагаар бүртгэж санхүүгийн тайланд тусгах зөвлөмжийг хүргүүлэв.


1.5.2. Өмнөх оноос шилжиж ирсэн авлагын шалтгааны тодруулж, барагдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Нийгмийн даатгалын авлагыг барагдуулах ажлыг орлого, шимтгэл хариуцсан байцаагч нар хариуцаж, албан шаардлага хүргүүлж, зарим байгууллагатай шимтгэлийг барагдуулах хуваарьтай гэрээ байгуулсан, Нийгмийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу банкны гүйлгээг зогсоох мэдэгдлийг хүргүүлж, тухай бүр нь арга хэмжээ авч ирсэн байна. Аудитын явцад гаргуулсан судалгаагаар 2012-2015 онд өгсөн албан шаардлага, банкны гүйлгээ зогсоосон мэдэгдлийг гаргаж ирүүлээгүй бөгөөд 2016 онд 353.9 сая төгрөгийн 61 албан шаардлага, 452.5 сая төгрөгийн 43 гүйлгээг зогсоох банкны мэдэгдэл хүргүүлжээ. Харин 2017 онд 353.9 сая төгрөгийн 23 албан шаардлага, 182.5 сая төгрөгийн 18 гүйлгээг зогсоох мэдэгдэл хүргүүлсэн бол 2018 онд 44.4 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлсэн нь авлагыг бууруулах арга хэмжээг хангалттай хэрэгжүүлээгүй, хяналтын байгууллагад шилжүүлж асуудлыг шийдвэрлээгүй байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг байгууллагын төрлөөр авч үзвэл нийт авлагын 93.0-82.6 хувийг хувийн өмчит байгууллагуудаас авах, 7.0-17.4 хувийг төсөвт байгууллагуудаас авах НДШ-ийн авлага эзэлж байна. /Судалгаа хавсралт №2/

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд авлагаар тусгасан зарим авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Дүрслэл 6. Нийт авлагад эзлэх хувийн жин



Аудитын илрүүлэлт

- 2012, 2013 оны санхүүгийн тайланг НДЕГ-т хүргүүлсэн тул бусад авлагын задаргааг гаргах боломжгүй байгаа ба санхүүгийн тайланд тусгасан бусад авлагын 12180300 тоот дансаар бүртгэсэн авлагыг судалж үзэхэд 2014 оноос хойш 14 байгууллага, иргэнтэй холбоотой 13.4 сая төгрөг барагдаагүй, санхүүгийн тайланд авлагын үлдэгдлээр байна.

Иймд тус авлагын эзэн холбогдогчийг тогтоож, хууль хяналтын байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг Нийгмийн даатгалын хэлтсийн даргад хүргүүлэв.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй 170 аж ахуйн нэгжийн 385.9 сая төгрөгийн авлагыг барагдуулсан байдлыг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар авч үзэхэд 57 аж ахуйн нэгж өмнөх оны авлагаас 94.5 сая төгрөгийг барагдуулж, 291.4 сая төгрөгийг барагдуулаагүй байна.

Иймд өмнөх онуудад авлагаар бүртгэсэн нийгмийн даатгалын шимтгэлийн болон бусад авлагын барагдаагүй үлдэгдлийг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн НДХ-т хүргүүлэв.

³⁵ “нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь” гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг”

³⁶ “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ..... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”

БҮЛЭГ 2. Төсвийн захирагч нь хууль зөрчсөн шийдвэр гаргасны улмаас ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт төсвөөс 5.8 сая төгрөг олгож үргүй зардал гаргасан байна.

2.1. Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлээгүйгээс төсөвт учирсан 5.8 сая төгрөгийн хохирлыг барагдуулаагүй байна.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагчдаас 2012-2018 онд орон байраар хангах, орон сууцны дэмжлэг авсан албан хаагч байхгүй бөгөөд тус онуудад ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 36.9 сая, ажилчдын шагнал урамшуулалд 40.9 сая, өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтнуудын төрөөс олгох нэг удаагийн буцалтгүй тусламжид 158.7 сая, ажлаас хууль бусаар чөлөөлөгдсөн ажилтнуудын нөхөн олговорт 5.8 сая нийт 242.3 сая төгрөгийн тэтгэмж, шагнал урамшуулал, нөхөн олговор олгосон байна.

Хүснэгт 23. Ажилчдад олгох нийгмийн хамгааллын зардлын судалгаа

№	Зардлын төрөл	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	НИЙТ
1	Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр олгосон тэтгэмж	4.8	4.7	6.4	3.1	9.2	5.9	2.8	36.9
2	Шагнал, урамшуулал	0.2	1.7	6.4	10.7	15.9	2.0	4.1	40.9
3	Өндөр насны тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж	19.6	-	-	20.7	55.6	16.0	46.7	158.7
4	Ажлаас хууль бусаар чөлөөлөгдсөн ажилтнуудын нөхөн олговор	-	-	-	-	0.9	4.9	-	5.8
	НИЙТ	24.6	6.4	12.7	34.5	81.7	28.8	53.6	242.3

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2016 оны А/20, 2017 оны А/04 тоот тушаалуудаар хэлтсийн хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан ба тус журмын хүрээнд ажилтнуудад тэтгэмж, шагнал урамшуулал, 2012-2018 онд өндөр насны тэтгэвэрт гарсан 10 ажилтны нэг удаагийн буцалтгүй тусламжийг Засгийн газрын тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”, Төрийн албаны тухай хуулийн хуулийн дагуу батлагдсан төсвийн хүрээнд олгожээ.

Тус хэлтсээс ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагч Шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргаж, шүүхийн шийдвэрийн дагуу 5.8 сая төгрөгийн нөхөн олговрыг төсвөөс олгосон ч Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5³⁷, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1³⁸-т заасны дагуу буруу шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнуудаар төлүүлж, төсөвт учирсан хохирлыг барагдуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэвэрийн байцаагчаар ажиллаж байсан Л.Мөнхцацралын нэхэмжлэлийн дагуу Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.01.29-ний өдрийн 05 тоот шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалин 3.2 сая төгрөгийг Нийгмийн даатгалын хэлтсээс гаргуулахаар шийдвэрлэснээс 2016.11.07-д Л.Мөнхцацралд 0.6 сая төгрөгийг олгож, ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн мэдээлж нийгмийн даатгалын шимтгэлд 0.4 сая төгрөгийг төсвөөс төлсөн байна.
- Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан А.Цэрмаагийн нэхэмжлэлийн дагуу Баянхонгор аймаг сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017.03.27-ний өдрийн 131/ШШ2017/00247 тоот шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалин 4.7 сая төгрөг, өмгөөллийн зардал 2.0 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 0.1 сая нийт 6.9 сая төгрөгийг А.Цэрмаад олгохоор шийдвэрлэсний дагуу цалинд 4.1 сая, нийгмийн даатгалын шимтгэлд 0.3 сая нийт 4.4 сая төгрөгийг Нийгмийн даатгалын хэлтсийн төсвөөс төлсөн байна. Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Нийгмийн даатгалын хэлтсийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “цалингийн сангаас олгосон А.Цэрмаагийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 4.1 сая төгрөгийг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2³⁹-т заасны дагуу дээд шатны дотоод аудитын нэгжид асуудлыг шилжүүлэн шийдвэрлүүлэх” гэсэн зөвлөмж өгсөн

³⁷ 498.5.Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.

³⁸ 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.

³⁹ 103.2.Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.

байна. Тус зөвлөмжийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газарт асуудлыг тавьсан ч НДЕГ-ийн дотоод аудит, мониторингийн газрын 2018.10.22-ний өдрийн 7/2383 тоот албан бичгээр "... хуульд заасны дагуу тус хэлтсээс Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлэх нь зүйтэй" гэжээ.


Иймд хууль бус үндэслэлээр ажлаас халагдсан ажилтнуудад олгосон нөхөн олговрыг хуулийн дагуу холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлж төсөвт учирсан хохирлыг барагдуулах зөвлөмжийг Нийгмийн даатгалын хэлтсийн даргад хүргүүлэв.

2.2. Аймгийн НДХ 2012-2018 онуудад шаардлагатай байгаа хөрөнгийн жагсаалт гарган эрэмбэлэн нэн шаардлагатай байгаа хөрөнгийг тухайн ондоо төлөвлөн ажилласан байна.

2.2.1.1 Баянхонгор аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтэс нь 2012-2018 онд суудлын автомашин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахад шаардлагатай байгаа хөрөнгийн санхүүжилтийг төсөвт тусгуулах саналыг НДЕГ-т гарган төсвийн төсөлд санал оруулснаар хөрөнгө оруулалтын зардлыг тухайн оны төсөвт батлуулсан байна.

Аймгийн НДХ-ийн 2013, 2014, 2015, 2016 оны санхүүгийн тайланд тухайн жилийн үйл ажиллагааны зардлаас хөрөнгө худалдан авахаар нийт 359.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 338.7 сая төгрөг зарцуулсан байна.

Дүрслэл 7. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/



2.2.2. 2015 оны хэлтсийн барилгын их засвар, угтах үйлчилгээний хэсгийн өргөтгөлийн барилгын газрын зөвшөөрлийг Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын даргын 2014 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 04/14 тоот зургийн даалгавраар олгосон ба инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөл гаргуулах ажил хийгдээгүй байна.

2.2.3. Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар, барилгын үүдэн хэсгийн өргөтгөлийн ажлын төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг 2015 онд "ЦЭСДА" ХХК гаргасан бөгөөд Барилга хөгжлийн төвийн 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн №339/2015 тоот дүгнэлтээр батлуулсан байна.

2.2.4. Хэлтсийн барилгын их засвар, барилгын үүдэн хэсгийн өргөтгөлийн барилгын ажлын төсөл, арга хэмжээний зураг, төсөвт өөрчлөлт ороогүй байна.

2.2.5. Хөрөнгө оруулалтаар их засварын ажил хийх, тоног төхөөрөмжийг бэлтгэх зардлыг батлуулахдаа хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байна.

2.3 Аймгийн НДХ нь сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 2016 онд үндсэн хөрөнгө худалдан авах тендерийг зохион байгуулсан бөгөөд тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны АЗ сертификатгүй гишүүн томилж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар 46.1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

2.3.1 Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнээс дээш төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээнээс 2015 онд хэрэгжүүлсэн 210.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хэлтсийн барилгын их засвар, өргөтгөлийн ажил, 2016 онд батлагдсан 90.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий суудлын автомашин худалдан авах ажлын худалдан авах ажиллагааг НДЕГ-т зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Харин 2016 онд хөрөнгө оруулалтын зардалд батлагдсан 25.0 сая төгрөгийн өртөг бүхий тавилга эд хогшил худалдан авах ажлын худалдан авах ажиллагааг аймгийн НДХ зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2016 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/18 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба үнэлгээний хорооны даргаар Санхүү бүртгэл, орлого бүрдүүлэлт тасгийн дарга, ахлах нягтлан бодогч С.Хонгорзул, гишүүдэд үйл ажиллагааны нягтлан бодогч У.Өлзийбаяр, Сангийн орлого, зарлагын тооцооны нягтлан бодогч Х.Дэмбэрэл нарыг томилсноос

үнэлгээний хорооны гишүүдэд худалдан авах ажиллагааны АЗ сертификатгүй нэг хүн томилсон байгаа нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 47.6⁴⁰ дугаар заалтыг зөрчсөн байна.

2.3.2 Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулан ажилласан байна.

2.3.3. НДХ-нь тавилга эд хошил худалдан авах ажиллагааны зарыг www.tender.gov.mn сайтад байршуулан, “Сод совин” ХХК, “Баялаг Богд” ХХК, “Ас холдинг” ХХК компаниудад урилгыг хүргүүлсээр тендерт оролцогчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Тендерт “Асхолдинг” ХХК-нь 24.7 сая төгрөгийн үнийн санал бүхий тендерийн баримт бичгийг ирүүлсэн байна. Уг тендерт өөр өрсөлдөгч компани оролцоогүй бөгөөд “Асхолдинг” ХХК-ний ирүүлсэн материал тендерийн шалгуурыг хангаж байсан тул гэрээ байгуулах эрх олгох саналыг НДХ-ийн даргад хүргүүлж тус компанитай гэрээ байгуулж ажилласан байна.

2.3.4 Худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж шууд гэрээ байгуулаагүй байна.

2.3.5. Аймгийн НДХ нь 2016 оны бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр тайланг нийгмийн даатгалын нэгдсэн сайтад байршуулсан байна.

2.4 Байгууллагын хэрэгцээнд 2014 онд худалдан авсан тавилга эд хогшлыг гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй байсан зөрчилд Төрийн аудитын газраас төлбөрийн акт тогтоосон байна.

2.4.1 Аймгийн НДХ хөрөнгө оруулалтаар хийгдэх 338.7 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээг гүйцэтгэгч ААН-үүдтэй гэрээ байгуулж ажилласан ба 136.6 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгэж, 197.1 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ гэрээний хугацаандаа хийгдээгүй, 5.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 24. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

сая.төг

№	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Гүйцэтгэгч ААН-ийн нэр	Ажил гүйцэтгэж дуусах хугацаа	Хүлээлгэн өгсөн хугацаа
1	Тавилга хэрэгсэл худалдан авах	5	“Баянхонгор констракшин” ХХК	2013.04.20	2013.04.20
2	Тавилга хэрэгсэл худалдан авах	5	“Ханбаянхонгор” ХХК	Тухайн ажил гэрээндээ хийгдээгүй байна.	Хүлээлгэн өгөөгүй тул төлбөрийн акт тогтоогдсон.
3	Хэлтсийн барилгын их засварын ажил	189.9	“ТЭ ТҮ” ХХК	2015.11.12	2016.01.31
4	Тавилга хэрэгсэл худалдан авах	10	“Говь хангай мебель” ХХК	2015.11.13	2015.11.13
5	Хяналтын камер	7	Зоригтболд ХХК	2015.04.21	2015.04.21
6	Авто тээврийн хэрэгсэл худалдан авах	89.9	“Вагнар ази автомотив” ХХК	2015.04.20	2016.04.13
7	Тавилга хэрэгсэл худалдан авах	24.7	“Асхолдинг” ХХК	2016.04.19	2016.04.19
8	Их засварын зураг төсвийн үнэ	7.2			
9	Нийт дүн	338.7			

Тус хэлтсийн 189.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий их засварын ажлыг “ТЭТҮ” ХХК 2015.08.27-ны өдрөөс 2015.11.12-ны хооронд хийж гүйцэтгэх гэрээг НДЕГ-тай байгуулсан байна. Гүйцэтгэгч компани засвар, өргөтгөлийн ажлыг гүйцэтгэх явцад барилгын дотор цахилгаан монтажийг бүрэн шинэчлэх шаардлага гарсантай холбоотой гэрээний хугацааг сунгуулах хүсэлт гаргаж 2016.01.18-ны өдөр БХР/ИЗ/16/01 тоот нэмэлт гэрээг байгуулж гэрээний хугацааг сунгасан байна.

Их засвар, өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгснөөс хойш Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6⁴¹-д заасан 3 жилийн хугацаанд гэмтэл гараагүй, одоо хэвийн ашиглагдаж байгаа талаар аймгийн НДХ-ийн даргын 2019.10.22-ны өдрийн 439 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

“Вагнар ази автомотив” ХХК гэрээний дагуу 89.9 сая төгрөгийн үнэ бүхий “Ford”-маркийн автомашин, “Асхолдинг” ХХК 24.7 сая төгрөгийн үнэ бүхий тавилга эд хөрөнгө болон

⁴⁰ Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна

⁴¹ 14.6.Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

бусад төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагууд нь гэрээний хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын явцад “Говьхангай мебель” ХХК-ний нийлүүлсэн 9 нэр төрлийн 10.0 сая, “Асхолдинг” ХХК-ний нийлүүлсэн 26 нэр төрлийн 24.7 сая төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшилд биет тооллого хийхэд гэрээний дагуу нийлүүлсэн бөгөөд бүрэн ашиглагдаж байна.

2.4.2 Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн хөрөнгө оруулалтын зардлаас 197.1 сая төгрөгийн барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн бол 141.6 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авахад батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж хөрөнгийг орлогоор бүртгэсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засварын ажлын гүйцэтгэх гэрээгээр 189.9 сая төгрөгөөр “ТЭТҮ” ХХК-тай НДЕГ

Хүснэгт 25. Хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл					сая.төг
Зардал	2013 он	2014 он	2015 он	2016 он	НИЙТ
Их засвар, өргөтгөл			197.1		197.1
Тоног төхөөрөмж			7.0		7.0
Тээврийн хэрэгсэл				89.9	89.9
Тавилга эд хогшил	5.0	5.0	10.0	24.7	44.7
НИЙТ	5.0	5.0	214.1	114.6	338.7

байгуулсан ба гэрээнд барилгын төсвийн үнийг гүйцэтгэгчээс суутган тооцохоор тусгаагүй, харин хэлтсийн хөрөнгө оруулалтын зардалд зураг төсвийн үнэ 7.2 сая төгрөг баталж өгснийг зураг төсвийн гүйцэтгэгч “ЦЭСДА” ХХК-д шилжүүлжээ.

Тус төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг НДЕГ зохион байгуулж гэрээн байгуулсан тул холбогдох материал аймгийн НДХ-т байхгүйгээс тодруулж үзэх боломжгүй байгаа тул УАГ-ын ГАГ нь худалдан авах ажиллагааны материалыг шалгахдаа дээрх арга хэмжээний хяналтын төсөвт зураг төсвийн үнэ тусгагдсан эсэх, гүйцэтгэгч компанид олгосон санхүүжилтээс зураг төсвийн үнийг суутган тооцох эсэхийг тодруулж үзэх шаардлагатай байна.

Нийгмийн даатгалын хэлтэст 2012-2018 онд НДЕГ-ын дэргэдэх “Тооцоолох төв”-өөс хөрөнгө хуваарилалтаар 40.4 сая, тус төвөөс балансаас баланст шилжүүлгээр 174.1 сая, аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүйгээр 1.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Говь-Алтай аймгийн НДХ-ээс балансаас баланст шилжүүлгээр 20.0 сая төгрөгийн суудлын автомашин зэрэг нийт 235.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирснийг байгууллагын хөрөнгөд орлогоор бүртгэжээ.

2.4.3 Хөрөнгө оруулалтын зардлаар 2012-2018 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгосон байна.

Харин 2014 онд батлагдсан 5.0 сая төгрөгийн зардлаас тавилга хэрэгсэл худалдан авах гэрээг “Ханбаянхонгор” ХХК-тай байгуулсан боловч тухайн ажил гэрээндээ хийгдээгүй байсан зөрчилд Төрийн аудитын газраас НДХ-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар төлбөрийн акт тогтоосон ч тус төлбөрийг одоо болтол барагдуулаагүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

2.4.4 Их засварын ажлын техник хяналтын гэрээг 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр 2016/02 дугаартай гэрээг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, “ТЭТҮ” ХХК, мэргэшсэн инженер Т.Энхтуяа нар их засварын ажлын техник хяналтыг хийх гуравласан гэрээ байгуулан хяналт тавьж ажилласан ба хяналтын явцад гарсан зөрчлүүдийг тухай бүрт нь дахин засварлуулан ажилласан тухай тайлбар тэмдэглэл хөтөлсөн байна.

2.5. Урсгал болон хөрөнгийн зардалд тавих хөндлөнгийн болон дотоод хяналт үр дүнтэй хэрэгжүүлэн илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт нь арилган ажилласан байна.

2.5.2. Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 12.а⁴²-д заасан үүргийн дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд НДЕГ-аас 2012, 2014, 2016, 2018 онуудад хяналт шалгалт хийгдсэн бөгөөд шалгалтаар үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалттай холбоотой ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй байна. Мөн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас жил бүр санхүүгийн тайлангийн аудит хийж 11.3 сая, 2015, 2016 онд аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас хэлтсийн үйл


12.а Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хөндлөнгийн хяналт тавих үүрэгтэй

ажиллагаанд шалгалт хийж 9.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг бүрэн биелүүлж ажиллажээ.

Хөндлөнгийн хяналтын байгууллагаар хийсэн шалгалтын дүн, дүгнэлтэд үндэслэн өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байгаад цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аудитаар 30 ажил олгогч, 172 даатгуулагчдаас авсан санал асуулгаар НДШ-ийн хувь хэмжээ өндөр, бууруулах шаардлагатай, цаашид нэмэгдүүлэхгүй байх, НДШ-ийн талаар иргэдэд мэдээлэл сайн өгөх, ач холбогдол үр дүнг сайн ойлгуулах хэрэгтэй, эмийн хөнгөлөлт дандаа дууссан байдаг гэсэн саналуудыг өгч байна. Мөн аймгийн НДХ болон ЭМД-ын тасгийн зарим ажиллагсад нь зан харилцаа, ёс зүй муутай, харьцахад хүндрэлтэй байдаг, үйлчлүүлэхэд чирэгдэл ихтэй гэсэн саналууд өгсөн байгаа тул байгууллагын удирдлагууд цаашид энэ асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дүрслэл 8. Нийгмийн даатгалын үйлчилгээг хэрхэн үнэлэх вэ?




Аудитын явцад авсан санал асуулгад хамрагдсан 172 даатгуулагчийн 41 нь нийгмийн даатгал төлдөггүй иргэн байгаа бөгөөд шимтгэлийн хувь хэмжээ өндөр байгаагаас нийгмийн даатгалд хамрагдаагүй гэж хариулжээ.


Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ авсан иргэдийн 60% нь боломжийн, 40% нь чирэгдэл учруулдаг үйлчилгээ муу гэж үзсэн байна.

Санал асуулгад оролцсон иргэдийн 58.7% буюу 101 иргэн нь нийгмийн даатгалд заавал даатгуулах нь зүйтэй гэж үзсэн хэдий ч иргэдийн 72.1% буюу 124 иргэн нийгмийн даатгалын талаар сайн мэдэхгүй гэж хариулсан байна.

Дүрслэл 9. Та нийгмийн даатгалд хамрагдах нь хэр зохистой гэж үздэг вэ?




Дүрслэл 10. Та нийгмийн даатгалын талаар хэр мэдлэг, мэдээлэлтэй вэ?



“Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын өнөөгийн тогтолцоо нь таны ирээдүйн нийгмийн баталгааг хангаж чадна гэдэгт итгэж байна уу?” гэсэн асуултад 62 иргэн нь итгэж байна гэж хариулсан бол 67 иргэн нь “Үгүй”, 43 иргэн нь “Мэдэхгүй” гэж хариулсан бөгөөд нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулах талаар

Дүрслэл 11. Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ хүртээмжтэй байна уу?



“Нийгмийн даатгалд хүн бүрийг хамруулах нь зүйтэй, ард иргэдийг тодорхой мэдээллээр хангаж зөвлөгөө өгч байх шаардлагатай, 1995 оноос өмнө өндөр настны тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийн зөрүүг арилган 1995 оноос хойш тэтгэвэр тогтоож байгаа итгэлцүүрээр бодож олгох, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай гэж

дийлэнх иргэд үзсэн бол 2 иргэн танил талаа харж группэд оруулдаг байдлыг зогсоох хэрэгтэй” гэсэн саналуудыг өгчээ.

Санал асуулгад оролцсон иргэдийн 26.7 хувь буюу 46 иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, 47.7% буюу 82 иргэн нь хүртээмж муутай гэж үзсэн бөгөөд мэдэхгүй гэж 25.6% буюу 44 иргэн хариулжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах тусламж, үйлчилгээг сайжруулахын тулд эрүүл мэндийн үйлчилгээ авч чадаагүй даатгалын үйлчилгээ авч чадаагүй тохиолдолд даатгалын мөнгийг буцааж авч байх, үйлчилгээний талаарх сурталчилгааг сайжруулах зэрэг ажлыг хийх шаардлагатай гэж үзжээ.

Аудитаар нийт 354.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 42.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 312.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Тус тайлан нь ҮАГ-ын хэмжээнд нэгтгэгдэн Монгол улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталгаажсаны дараагаар төлбөрийн актыг хүргүүлэх болно. Иймд актыг хүргүүлсэн үед нь сонсох ажиллагаа хийж ажиллана уу.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн тайлантай холбоотой аймгийн НДХ-ийн 2019.11.14-ний өдрийн 459 тоот, ЭМД-ын тасгийн 2019.11.14-ний өдрийн 15 тоот албан бичгүүдээр дараах саналуудыг ирүүлсэн байна.



Тус хэлтэст “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, саналаа хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

Хүндэтгэсэн

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Б. Даминзор
Саналыг суурийн
Тайлагч Г.СОНГО
2019.11.14
2519824

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ ГАРГАСАН САНАЛ

2019 оны 11 дүгээр сарын 14

Номгон

Тус хэлтсийн үйл ажиллагаанд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Тайлантай холбогдуулан дараах саналыг хүргүүлж байна.

Санал-1: Эрдэнэцогт сумын даатгуулагч Ж.Оюунтуяад илүү олгосон тэтгэвэртэй холбоотой акт төлбөрийг барагдуулсан баримтаа олох хүртлээ энд дурьдсан актыг хүлээн зөвшөөрч байна.

Санал-2: Тэтгэвэр авагчийн хөдөлгөөн тухай бүр зөв хийж байгаагүй, буруу регистрийн дугаар дээр тэтгэвэр олголт шивэгдсэн, нас барсны дараа сарын тэтгэвэр илүү олгосон, давхар олгосон зэрэг зөрчлүүдийг аудитын зөрчлөөс хасуулах саналтай байна.

Санал-3: 2014 онд 300.000 төгрөгийн оршуулгын тэтгэмжийг хугацаа хэтрүүлэн олгосон зөрчлийн хувьд даатгуулагч Б.Дуламсүрэн нь нас бараад 7 жил болсон, түүний ар гэрийнхэнтэй нь холбогдох боломжгүй, эргэн төлөгдөх магадлал маш бага тул найдваргүй авлага, төлөгдөх боломжгүй төлбөр зөрчлийн тоо нэмэгдэх тул аудитын зөрчлөөс хасуулах саналтай байна.

Санал-4: Найдваргүй авлагын сан байгуулж ажиллаагүй тухайд зөрчлийн жагсаалтаас хасч, ҮАГ болон НДЕГ-т хүргүүлэх саналын жагсаалтанд бүртгэж өгнө үү.

Санал-5: Өмнөх онуудад хийгдэж байсан шалгалттай харьцуулан үнэлж, дүгнэлт гаргана уу.

Санал-6: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлж ажилласан зөрчлийг хасуулах саналтай байна.

САНАЛ ГАРГАСАН

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
ТАСГИЙН ДАРГА  П.БОЛОРМАА



ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАРИУЦСАН
УЛСЫН БАЙЦААГЧ А.МӨРӨНГОО

ОРЛОГО, ШИМТГЭЛ ХАРИУЦСАН УЛСЫН
БАЙЦААГЧ  Н.ДОГМИДСАНГИ



МАГАДЛАГЧ ИХ ЭМЧ, ТЭТГЭМЖИЙН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ Т.ЦЭРЭННАДМИД

ТЭТГЭМЖ ХАРИУЦСАН УЛСЫН
БАЙЦААГЧ  Ч.АЛТАНЦЭЦЭГ



ТЭТГЭВЭР ХАРИУЦСАН УЛСЫН
БАЙЦААГЧ  С.ДАВААЖАВ





**ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ТАСАГ**

64101 Номгон, Баянхонгор сум,
Утас/Факс: (976)-70442162

2019. 11.14 № 15

танай _____ -ны № _____ -т

Г Хүсэлт хүргүүлэх тухай Г

337

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас "Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараахь тайлбарыг хүргүүлж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын цахим системд гэрээ бүхий байгууллагуудаас сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон гүйцэтгэлийг ажлын 3 өдрийн дотор авч дараа сард ЭМДЕГазраас санхүүжилтийг олгож байгаа. Иймд санхүүжилт сар дамжин орж байгаагаас үүдэн өр авлага үүсч буй асуудлыг гэрээнд өөрчлөлт оруулах, урьдчилгаа өгөх зэргээр шийдвэрлэж болох тул үүнийг ЭМЯ, ЭМДЕГазарт санал, зөвлөмж хүргүүлэх нь зүйтэй. Орон нутгийн тасгууд санхүүжилт өгөх эрх, хууль зүйн чадамжгүй билээ.

2. Магадлан итгэмжлэгдсэн Рашаан сувилалууд 2 жил тутам ЭМДЕГазраас зарладаг сонгон шалгаруулалтанд тэнцсэн бол ЭМДЕГазартай гэрээ байгуулдаг. Төрөөс хариуцах болон эрүүл мэндийн даатгалаа өөрөө төлдөг гээд даатгалын хураамжаа төлсөн иргэн бүр рашаан сувилалд 7 дээш хоног амарсан бол ЭМД сангаас 110000 төгрөгөөр рашаан сувилалыг санхүүжүүлдэг. Халамжийн сангаас өгч буй ахмад настны хөнгөлөлт хуулийн дагуу тухайн хүндээ очих тул энд дурьдсан зөвлөмжийг Рашаан сувилал, ХХҮГ-т хамааруулан хүргүүлэх нь зүйтэй.

ДАРГА

A.T.S

А.ЦЭРМАА

Б.Аалмаа
Санал бол сурагч
Төлбөрийг хүлээн

2019.11.14

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

№	Санал	Саналд өгсөн тайлбар
1	АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН САНАЛ-1	Тус тэтгэвэр авагчийн 2014.07.13-2015.01.15 хүртэл хугацааны тэтгэврийг буцаан төлүүлэхээр тооцож, хэлтсийн дотоод хяналт шалгалтаар акт тогтоож төлүүлсэн нь баримтаар нотлогдохгүй байгаа тул тус хугацааны тэтгэвэр болох 1.2 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож саналыг хүлээж аваагүй болно.
2	АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН САНАЛ-2	НДХ-ийн ирүүлсэн нэмэлт нотлох баримт болох тус иргэдийн тэтгэврийг төлүүлсэн дансны хуулгаар нотлогдож байгаа тул саналын дагуу шийдвэрлэв.
3	АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН САНАЛ-3	Хууль зөрчиж сангаас илүү зардал гаргасан тул саналыг хүлээж авах боломжгүй.
4	АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН САНАЛ-4	Саналыг хүлээж авсан.
5	АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН САНАЛ-5	Аудит нь 2012-2018 оныг хамруулан шалгаж байгаа, өмнөх шалгалтууд нь өөр зорилт чиглэлээр зөвхөн нэг жилийг хамруулсан тул харьцуулж дүгнэх боломжгүй тул саналыг хүлээж аваагүй.
6	АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН САНАЛ-6	Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд үндэслэн дүгнэлтээ өгч байгаа тул саналыг хүлээж авах боломжгүй.
7	АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАСГИЙН САНАЛ-1	Саналыг хүлээж авч ЭМДЕГ-т мөн тус саналыг хүргүүлж байгаа болно.
8	АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАСГИЙН САНАЛ-2	Саналын дагуу ХХҮЕГ-хүргүүлэхээр санал ҮАГ-т хүргүүлж хүлээж авсан.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Даатгуулагчийн ажилласан жилийг өмнөх онуудад улсын хэмжээнд зохион байгуулсан аяны хүрээнд нийгмийн даатгалын улсын байцаагч баталгаажуулсан байгааг одоо үгүйсгэж Төрийн албаны залгамж чанар алдагдаж байгаагаас иргэд хохирч ажилласан жилээ дахин нотлох хүндрэл үүсч байна.
2. Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтод тавих өдөр тутмын хяналтыг тэтгэврийн болон хяналт шалгалтын байцаагч нар үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс зөрчил дутагдал арилахгүй давтагдан гарч байгаа ба хяналт, шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг бүрэн барагдуулаагүй байна.
3. ЭМД-ийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт зохих хэмжээгээр сайжирч байгаа ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зарим зардлын санхүүжилтийг давхардуулан олгосон зөрчил гарсаар байна.
4. ЭМД-ын сангаас иргэдэд хөнгөлөлттэй үнээр эм олгох, түүнд хяналт тавих ажлыг улсын хэмжээнд цахим хэлбэрт шилжүүлж, эрүүл мэндийн байгууллага, эмийн сангуудын харилцан уялдаа бүхий санхүүгийн программыг шинэчлэн сайжруулж ашигласнаар хөнгөлөлттэй эмийн зарцуулалтад тавих хяналт сайжирсан байна.
5. Хөдөөгийн иргэдийн эмийн үнийн хөнгөлөлтийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, сумын ЭЭСан нь энэ талын сургалт, сурталчилгаа хангалтгүй хийдгээс хөнгөлөлттэй үнээр борлуулах эмийн батлагдсан төсвийг бүрэн ашиглаж чадахгүй байна.
6. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлтөд батлагдсан зардлыг аймаг, сумдын хүн амын сууршлийг харгалзан оновчтой хуваарилаагүйгээс зарим сумд төлөвлөсөн хэмжээнд зардлыг бүрэн зарцуулаагүй байхад аймгийн төвд хуваарилсан зардал хүрэлцэхгүйгээс иргэдийн гомдол санал тасрахгүй байна.
7. Ажилгүйдлийн тэтгэмж тогтоохдоо хууль, журмын зөрүүтэй ойлголттой байгаагаас даатгуулагчдад олгох тэтгэмжийг адил тэгш нөхцөлөөр олгоогүй, НДҮЗ-ийн 2016 оны 22 дугаар тогтоолоор баталсан журмын 4.6 дахь заалтыг хэрэгжүүлж, ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлүүлээгүй байна.
8. Нийгмийн даатгалын хэлтэс нь он дамжсан авлагын үлдэгдэл ихтэй байхад түүнийг барагдуулах талаар тухай бүр нь үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллаагүй, хяналт шалгалтаар тогтоосон төлбөрийн актыг санхүүгийн тайланд авлагаар бүртгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
9. Хөдөлмөрийн тухай, Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлээгүйгээс байгууллагын ажиллагсдад олгосон нөхөн олговрын 5.8 сая төгрөгийн хохирлыг барагдуулаагүй байна.
10. Аймгийн НДХ нь 2016 онд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилохдоо ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар 46.1.1 дэх заалтыг зөрчсөн байна.
11. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөл нь Засгийн 1994 оны 171 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ажил олгогч даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан зөрөөг хянан шийдвэрлэх гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм"-ийн 14, 15 дугаар заалтыг хэрэгжүүлж иргэдээс ирсэн өргөдлийн хариуг хугацаанд нь өгөөгүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нэг. Аймгийн Нийгмийн даатгалын хэлстийн дарга Д.Мөнхбат танаа

1. Даатгуулагчийн өндөр насны тэтгэврийг тогтоохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3, Засгийн газрын 2018 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам"-ын 3.6 дахь заалтыг хэрэгжүүлж даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж байх.
2. Өндөр насны тэтгэврийг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тогтоогоогүй тэтгэвэр авагчдын тэтгэврийг 2019 оны 12 дугаар сараас эхлэн шинэчлэн тогтоож олгох.
3. Сангуудад хийсэн хяналт шалгалтаар илэрсэн төлбөрийн актын үлдэгдлийг 2019 оны 12 дугаар сарын 01-ний дотор хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.
4. Хяналт шалгалтаар тогтоосон төлбөрийн актыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтын дагуу санхүүгийн тайланд тухай бүр нь авлагаар бүртгэж, заасан хугацаанд нь барагдуулах арга хэмжээ авч ажиллаж байх.
5. Санхүүгийн тайланд тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон бусад авлагын барагдаагүй үлдэгдлийг 2019 оны 12 дугаар сарын 01-ний дотор хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэн барагдуулж ажиллах.
6. Ажилгүйдлийн тэтгэмжийг иргэдэд адил тэгш эрхтэйгээр тооцож, журмын дагуу олгож, хувийн хэргийн бүрдэлт, байгууллагуудаас авсан тодорхойлолтыг албажуулж байх
7. Ажилгүйдлийн тэтгэмж, цалин хөлс давхардсан тохиолдолд тооцооллыг үнэн зөв хийж, журамд заасны дагуу тэтгэмжийг санд тухай бүр нь буцаан төлүүлж, түүнд тавих хяналтыг сайжруулах.
8. Шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс олгосон нөхөн олговрыг холбогдох хуулийн дагуу буруутай албан тушаалтнуудаар төсөвт учирсан хохирлыг төлүүлэх нэхэмжлэлийг 2019 оны 12 дугаар сарын 01-ны дотор хууль хяналтын байгууллагад гаргах.
9. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТухай хуулийг хэрэгжүүлж, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Хоёр. Аймгийн Эрүүл мэндийн тасгийн дарга А.Цэрмаа танаа

1. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ"-нд заасны дагуу санхүүжилтийг сард хоёр удаа нэхэмжлэх заалтыг мөрдөж, санхүүжилтийг хугацаа алдалгүй олгож байх.
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож байгаа хөнгөлөлттэй эмийн үнийн зардлыг сумын хүн амын сууршил төвлөрөлтэй уялдуулан батлагдсан зардлыг аймгийн хэмжээнд оновчтой хуваарилж, цаашид санхүүжилтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2020 оны 04 дүгээр сарын 05-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

“Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнтэй холбогдуулан дараах саналыг хүргүүлэхээр уламжилж байна. Үүнд:

Нэг. Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.1.2, 13.1.1 заалтын дагуу НДҮЗ-ийн 2016 оны 19 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар сэргээн засах, үйлчилгээний хувьсах зардлын төлбөрийн хэмжээг 110.0 мянган төгрөгөөр тогтоосон, мөн Ахмад настны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т “эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох” гэсэн заалтуудаар ахмад настнууд нь рашаан сувилалд давхардуулан хөнгөлөлт авч байгаа нь Улсын төсөвт тодорхой хэмжээний ачаалал нэмэгдүүлж байгаа тул тус асуудлыг нэгдсэн тайланд үр ашиг талаас нь авч үзүүлэх саналтай байна.

Нэг. Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх санал

1. Ажилгүйдлийн даатгалын санг эрсдэлээс хамгаалах, зориудаар цалин өсгөж, ажилгүйдлийн тэтгэмжийг өндөр авдаг байдлыг зогсоох үүднээс сүүлийн 3 сарын дундаж гэдгийг 6 сараар болгож өөрчлөх болон холбогдох журмын талаар салбарын ажиллагсдадаа сургалт явуулж журмын талаарх ойлголтыг нэг мөр болгох.
2. Нийгмийн даатгалын сангийн программд ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн мэдээлэх 32 кодыг НДҮЗ-өөс 2016 онд баталсан “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ын 4.6-д заасантай нийцүүлэн ажилгүйдлийн тэтгэмж суутган тооцдог байхаар зохицуулах
3. Жирэмсэн амаржсаны тэтгэмж авах даатгуулагчийн тэтгэмжийн хувь хэмжээг тооцох, бодох, олгох аргачлалыг бүрэн зохицуулсан журмыг баталж хэрэгжүүлэх /Сайн дурын даатгуулагч ямар нөхцөлд тэтгэмж авахаас өмнө албан журмын даатгалд хамрагдсан байх нөхцөлийг тодорхой болгох/
4. 1995.01.01-ний өдрөөс өмнөх өндөр насны тэтгэвэр тогтоох ажилласан хугацааг тооцохдоо Засгийн газрын 1991 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Ажилласан хугацааг тооцох журам”-ын 1.5-д “БНМАУ-ын хууль тогтоомжид заасан журмын дагуу хөтлөгдсөн Хөдөлмөрийн дэвтэр нь ажилласан хугацааг тооцож тогтоох үндсэн баримт болно”, 6-т “Ажилласан хугацааг нь тооцох баримтгүй болсон иргэдийн ажилласан хугацааг шүүх тогтооно” гэсэн заалтын дагуу нийгмийн даатгалын байгууллагаас зохион байгуулсан иргэний хөдөлмөрийн дэвтрийн улсын үзлэгээр ажилласан хугацааг баталгаажуулсан байхад тэтгэвэр тооцоход үүнийг харгалзан үзэхгүй байна. Мөн одоо мөрдөгдөж байгаа НДЕГ-ын даргын 2010 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 163 тоот тушаалаар баталсан “Тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ын 3.1.4, 3.1.5. дахь заалтууд хэрэгжихгүйгээс иргэд хохирч байгаад анхаарч, үүнтэй холбоотой зөвлөмж, аргачлалыг гаргаж, асуудлыг тодорхой болгох шаардлагатай байна.

Хоёр. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргэх санал

1. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ”-нд заасны дагуу санхүүжилтийг сард хоёр удаа нэхэмжлэх заалтыг мөрдөж, санхүүжилтийг хугацаа алдалгүй олгож байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



ХАВСРАЛТУУД:

Хавсралтын нэр	Хуудасны тоо
Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын насжилтийн судалгаа	1 хуудас
Нийгмийн даатгалын авлагын судалгаа, байгууллагын төрлөөр	4 хуудас
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй аж ахуйн нэгжийн судалгаа /2012-2018 он/	10 хуудас
Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2012-2018 онуудад ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр олгосон санхүүжилтийн судалгаа	1 хуудас
Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2012-2018 онуудад ажилтнуудад олгосон шагнал, урамшууллын судалгаа	5 хуудас
Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2012-2018 онуудад ажилтнуудад олгосон нөхөн олговрын судалгаа	1 хуудас
Тайлан баталгаажуулсан тушаал	2 хуудас
Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	4 хуудас